

МАТАЙ

[1]

¹Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг .

²Абрахам Исаакийн эцэг, Исаак Иаковын эцэг, Иаков Иудагийн болон ах дүүсийнх нь эцэг болой. ³Иуда нь Перез, Зера нарын эцэг бөгөөд тэд Тамараас төржээ. Перез Хезроны эцэг, Хезрон Рамын эцэг, ⁴Рам Амминадабын эцэг, Амминадаб Нахшоны эцэг, Нахшон Салмоны эцэг юм. ⁵Салмонд Рахабаар Боаз, Боазд Рутаар Обед төржээ. Обед бол Иессийн эцэг, ⁶Иесси нь Давид хааны эцэг билээ.

Уриагийн эхнэрээс Давидад Соломон төрсөн ⁷бөгөөд Соломон Рехобоамын эцэг, Рехобоам Абиагийн эцэг, Абиа Асагийн эцэг юм. ⁸Аса Иехошафатын эцэг, Иехошафат Иорамын эцэг, Иорам Уззиагийн эцэг, ⁹Уззиа Иотамын эцэг, Иотам Ахазын эцэг, Ахаз Хезекиагийн эцэг, ¹⁰Хезекиа Манассегийн эцэг, Манассе Амоны эцэг, Амон Иосиагийн эцэг юм. ¹¹Вавилон уруу цөлөгдөх үед Иосиад Иекониа болон ах дүүс нь төржээ.

¹²Вавилон уруу цөлөгдсөний дараа Иекониад Шеалтиел, Шеалтиелд Зеруббабел нар төрөв. ¹³Зеруббабел Абихудын эцэг, Абихуд Елиакимын эцэг, Елиаким Азорын эцэг, ¹⁴Азор Задокийн эцэг, Задок Ахимын эцэг, Ахим Елиудын эцэг, ¹⁵Елиуд Елеазарын эцэг, Елеазар Маттаны эцэг, Маттан Иаковын эцэг юм. ¹⁶Иаков бол Христ хэмээгддэг Есүсийг төрүүлсэн Мариагийн нөхөр Иосефын эцэг болой.

¹⁷Ийнхүү Абрахамаас Давидыг хүртэл бүгд арван дөрвөн үе, Давидаас Вавилон уруу цөллөгдөх хүртэл арван дөрвөн үе, Вавилон уруу цөлөгдсөнөөс Христийн үеийг хүртэл арван дөрвөн үе байв.

¹⁸Есүс Христ ингэж мэндэлжээ. Есүсийн эх Мариа Иосефтой сүй тавиад, дэр нийлэхээсээ өмнө хэвлийдээ Ариун Сүнсээр хүүхэдтэй болсон байлаа. ¹⁹Нөхөр нь болох Иосеф зөвт хүн байсан бөгөөд Мариаг гутамшиг болгохыг үл хүссэн тул түүнээс нууцаар салах бодолтой байжээ. ²⁰Харин түүнийг тийн бодож байх үед Эзэний тэнгэр элч зүүдэнд нь үзэгдэж,

—Давидын хүү Иосеф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн. Учир нь түүнд олдоод байгаа нь Ариун Сүнснийх юм. ²¹Түүнийг Хүү төрүүлэхэд,

чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлэв. ²²Эдүгээ энэ бүхэн тохиолдсон нь Эзэн эш үзүүлэгчээр дамжуулан айлдсан нь биелэгдэхийн тулд бөгөөд ингэхдээ ²³«Харагтун, онгон бүсгүй Хүүхэдтэй болж Хүү төрүүлнэ. Тэгээд тэд Түүнийг Иммануел (орчуулбал «Бидэнтэй хамт буй Бурхан») гэж нэрлэнэ» гэсэн юм. ²⁴Иосеф нойрноосоо сэрж, Эзэний тэнгэр элчийн тушааснаар Мариаг эхнэрээ болгоод, ²⁵Хүүг төрүүлтэл түүнийг онгон хэвээр нь байлгасаар байв. Иосеф Түүнийг Есүс гэж нэрлэв.

[2]

¹Херод хааны өдрүүдэд Иудейн Бетлехем хотод Есүсийг төрсний дараа дорно зүгээс зурхайчид Иерусалимд хүрч ирээд,

— ²Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ? Бид зүүнтэйд Түүний одыг хараад Түүнд мөргөхөөр ирлээ гэжээ. ³Херод хаан болон бүх иерусалимчууд үүнийг сонсоод бачимдаж гэнэ. ⁴Тэгээд бүх ахлах тахилч болон хуулийн багш нарыг цуглуулаад, Христ хаана төрөх ёстойг тэр лавлаж эхлэв. ⁵Тэд түүнд

—Иудейн Бетлехемд, учир нь эш үзүүлэгчийн бичсэнээр

⁶"Иуда нутгийн Бетлехем ээ!

Чи Иудагийн дээдсийн дунд огтхон ч дорд биш.

Учир нь Миний ард түмэн Израилийн хоньчин болох Удирдагч чамаас гарна"

гэсэн гэж хариулав.

⁷Херод зурхайчдыг нууцаар дуудаж, од үзэгдсэн цагийг тэднээс лавлаж асуужээ. ⁸Тэр тэднийг Бетлехем уруу явуулж,

—Яв, тэр Хүүхдийг сайтар хай. Түүнийг олмогцоо надад мэдэгдэгтүн. Би бас очиж Түүнд мөргөнө гэлээ. ⁹Тэд хааны айлдварыг сонсоод замдаа гарав. Тэгтэл тэдний зүүнтэйд харсан од тэдний өмнө явсаар Хүүхдийн байсан газар хүрээд тогтов. ¹⁰Тэд одыг хараад, үлэмж баяр хөөр болж ихэд баярлажээ. ¹¹Тэгээд гэрт орж, эх Мариагийн хамт байгаа Хүүг хараад сөгдөн Түүнд мөргөж, эрдэнэсийн хайрцгаа нээгээд алт, гүгэл, мирийг бэлэг болгон барив.

— ¹²Херод уруу бүү буцаж оч гэж Бурхан зүүдэнд нь анхааруулсанд, тэд ондоо замаар нутгийн зүг одлоо.

¹³Тэднийг явсны дараа, Эзэний тэнгэр элч Иосефын зүүдэнд үзэгдэж

—Бос. Хүүхдийг эхтэй нь авч Египет уруу зугт. Намайг чамд хэл дуулгатал тэндээ бай. Учир нь Херод Хүүхдийг хөнөөхөөр эрж хайх гэж байна гэжээ. ¹⁴Иосеф босоод шөнөөр Хүүг эхтэй нь авч Египетийг зорин хөдөллөө. ¹⁵Тэгээд Херодыг нас бартал тэндээ байв. Эзэн эш үзүүлэгчээрээ дамжуулан «Би Хүүгээ Египетээс дуудан гаргав» гэсэн нь ийнхүү биелжээ.

¹⁶Херод зурхайчдад мэхлэгдсэнээ мэдээд ихэд хилэгнэн, тэднээс тодруулж авсан цагийн дагуу хүн явуулаад, Бетлехем болон түүний ойр орчимд хоёр болоод түүнээс доош насны эр хүйсний бүх хүүхдийг хөнөөлгөв. ¹⁷Эш үзүүлэгч Иеремиагаар дамжуулан хэлсэн нь тэр цагт биелэгдсэн агаад ингэхдээ

¹⁸«Ихэд гашуудан уйлах дуу Рамад сонсдов.

Рахел тайтгарлыг авахаас татгалзан,

Хүүхдүүдийнхээ төлөө уйлна.

Учир нь тэд нар нь байсангүй»

гэсэн байв.

¹⁹Харин Херодыг нас барсны дараа Египетэд Эзэний тэнгэр элч Иосефт зүүдэнд нь үзэгдэж,

— ²⁰Бос, Хүүг эхийнх нь хамт авч, Израиль нутагт оч. Хүүхдийн амийг хайгчид үхсэн гэв. ²¹Тэр босож Хүүг эхтэй нь авч, Израиль нутагт ирэв. ²²Харин Архел эцэг Херодынхоо оронд Иудейг хаанчилж байгааг тэр сонсоод тийш очихоос айжээ. Бурхан зүүдэнд нь сэрэмжлүүлснээр, тэр Галилын нутаг уруу явав. ²³Тэгээд Назар гэгдэх хотод очиж суурьшив. «Назарынх гэж Түүнийг дуудах болно» гэж эш үзүүлэгчдээр айлдуулсан нь ийнхүү биелэгджээ.

[3]

¹Тэр өдрүүдэд баптисм хүртээгч Иохан ирж, Иудейн цөлд сургаал айлдаж,

— ²Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж байлаа. ³Яг түүний тухай эш үзүүлэгч Исаиа

«Цөлд хашхирагч нэгний дуу,

"Эзэний замыг бэлтгэцгээ,

Түүний замыг шулуун болгоцгоо" гэнэ»

гэжээ. ⁴Иохан тэмээний ноосон дээл өмсөж, суран бүс бүсэлсэн байв. Хоол хүнс нь царцаа, зэрлэг зөгийн бал байсан аж. ⁵Тэгэхэд иерусалимынхан, бүх Иудей мөн Иордан хавийн бүх газар нутгийнхан түүн уруу ирж байлаа. ⁶Тэд нүглээ улайгаад, Иордан голд түүгээр баптисм хүртэж байв.

⁷Харин фарисайчууд болон садукайчуудаас олон хүн баптисм хүртэхээр ирж буйг тэр хараад, тэдэнд

—Хорт могойн удам аа, ирэх уур хилэнгээс зугт гэж хэн та нарт сануулсан юм бэ? ⁸Тийм бөгөөс гэмшилд зохистой үр жимс гарга. ⁹"Абрахам эцэг минь бидэнд байна" гэж өөрсөддөө хэлж болно хэмээн бүү бод. Би та нарт хэлье, Бурхан энэ чулуунуудаас ч Абрахамд хүүхдүүдийг босгож чадна. ¹⁰Моддын үндсэнд сүх хэдийнээ зоогджээ. Иймээс сайн үр жимс ургуулдаггүй аливаа мод цавчуулан, галд хаягдах болно. ¹¹Миний хувьд гэвэл, гэмшлийн чинь төлөө би та нарт усаар баптисм хүртээдэг. Харин миний араас Ирэгч надаас илүү хүчтэй бөгөөд Түүний шаахайг тайлах нь ч надад зохисгүй. Тэр та нарт Ариун Сүнсээр хийгээд галаар баптисм хүртээнэ. ¹²Түүний гарт нь шигшүүр байна. Тэр үтрэмээ гүйцэд цэвэрлээд, Өөрийн улаан буудайг саравчинд овоолж, харин хивэг хальсыг нь унтаршгүй галаар шатаана гэж хэлэв.

¹³Тэгээд Есүс Иоханаар баптисм хүртэхийн тулд Галилаас Иорданд түүн дээр ирэв. ¹⁴Харин Иохан

—Би Танаар баптисм хүртэх учиртай байтал Та над уруу ирнэ үү? гээд, Түүнийг болиулахыг оролдтол, ¹⁵Есүс хариуд нь

—Энэ удаад үүнийг зөвшөөр. Ингэснээрээ аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх нь бидэнд зохицож байна гэж хэлэхэд тэр Түүнд зөвшөөрөв. ¹⁶Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. ¹⁷Тэнгэрээс

—Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа.

[4]

¹Есүс диаволд соригдохоор цөл уруу Сүнсээр хөтлөгдөв. ²Тэр дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсны эцэст өлсжээ. ³Соригч ирээд, Түүнд

—Хэрэв Чи Бурханы Хүү мөн бол энэ чулуунуудыг талх бол гэж тушаа гэв. ⁴Гэвч Есүс

—"Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна" гэж бичигдсэн байдаг гэж хэлэв. ⁵Тэгэхэд диавол Түүнийг ариун хотод аваачиж, сүмийн орой дээр зогсоогоод, ⁶Түүнд

—Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол доошоо үсэр. Учир нь "Чамд санаа тавих үүргийг Тэр тэнгэр элч нартаа өгнө. Тэд гар дээрээ Чамайг өргөөд авч явна. Эс тэгвэл Чи хөлөө чулуунд цохьчих вий"

гэж бичигдсэн байдаг шүү дээ гэв. ⁷ Есүс

—"Өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь" гэж бас бичигдсэн байдаг гэв. ⁸Диавол дахин Түүнийг асар өндөр ууланд аваачаад дэлхийн бүх хаанчлалуудыг болон сүр хүчийг нь үзүүлээд,

— ⁹Хэрэв Чи сөхрөн, надад мөргөвөл, энэ бүхнийг би Чамд өгье гэж хэлэхэд ¹⁰Есүс

—Зайл, Сатан аа! "Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил" гэж бичигдсэн байдаг юм гэж хэллээ. ¹¹Тэгээд диавол Түүнийг орхиход, тэнгэр элч нар ирж Түүнд үйлчилж эхлэв.

¹²Есүс Иоханыг баривчлагдсаныг сонсоод, Галил уруу буцлаа. ¹³Тэр Назарыг орхиж, Зебулун болоод Нафталийн мужийн нуурын эрэг дэх Капернаумд ирж суурьшив. ¹⁴Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар хэлүүлсэн нь биелэгдсэн бөгөөд

¹⁵«Иорданы чанад тэнгис хүрэх зам дээрх Зебулуны болоод Нафталийн нутаг,

харь үндэстнүүдийн Галил,

¹⁶харанхуйд суугч хүмүүс агуу их гэрлийг харж,

үхлийн нутагт ба сүүдэрт суугчдын дээр гэрэл тусав»

гэсэн юм.

¹⁷Тэр цагаас эхлэн Есүс

—Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж тунхаглаж эхлэв.

¹⁸Тэр Галилын нуурын эргээр явж байхдаа ах дүү болох Петр гэгддэг Симон, түүний дүү Андрей нарыг нуурт тор тавьж байгааг харжээ. Тэд загасчид аж. ¹⁹Есүс тэдэнд

—Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно гэв. ²⁰Тэд тэр даруй тороо орхиж Түүнийг дагалаа. ²¹Тэр тэндээсээ цааш явж байгаад өөр нэг ах дүү болох Зебедеен хөвгүүн Иаков, түүний дүү Иохан хоёрыг завин дотроо эцэг Зебедеенхээ хамт загасны тороо сэлбэж байгааг хараад дуудав. ²²Тэр даруй тэд эцгээ завьтайгаа орхиж Түүнийг дагалаа.

²³Есүс бүх Галилаар явахдаа синагогуудад нь сургаал айлдаж, хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, олон түмний доторх алив төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа. ²⁴Түүний тухай зар бүх Сири даяар тархсанд, хүмүүс зовж шаналсан, чөтгөр шүглэсэн, унаж татдаг өвчтэй, саа өвчтэй бүхнийг Түүн дээр авчрахад Есүс тэднийг эдгээжээ. ²⁵Галил, Декаполис, Иерусалим, Иудей түүнчлэн Иорданы тэртээгээс үй олон хүн Түүнийг дагалаа.

[5]

¹ Есүс олон түмнийг хараад, уул өөд гарав. Түүнийг суусны дараа шавь нар нь Түүн дээр ирлээ. ²Тэр амаа нээн, тэдэнд сургаж эхлэв.

— ³Сүнсэн дотроо ядуу хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм.

⁴Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд тайвшрал авах болно.

⁵Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.

⁶Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд хангалуун болох болно.

⁷Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд өршөөл энэрлийг хүртэх болно.

⁸Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханыг харах болно.

⁹Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно.

¹⁰Зөвт байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. ¹¹Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй ээ! ¹²Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд

тийнхүү хавчсан юм. ¹³Та нар бол газрын давс. Хэрэв давс амтаа алдвал дахиад яаж давслаг болгох вэ? Энэ нь гадагшаа хаягдаж, хүмүүсийн хөл доор гишгэгдэхээс өөр юунд ч хэрэг болдоггүй. ¹⁴Та нар бол дэлхийн гэрэл мөн. Уулан дээрх хот нуугдаж үл чадна. ¹⁵Хүмүүс дэнлүү асаагаад савны доор тавьдаггүй, харин дэнлүүний суурин дээр тавьдаг. Тэр нь гэрт байгаа бүгдэд гэрлээ тусгадаг билээ. ¹⁶Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг.

¹⁷Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм. ¹⁸Үнэнээр Би та нарт хэлье, тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй. ¹⁹Хэн боловч эдгээр тушаалуудаас хамгийн өчүүхнийг нь ч үл тоомсорлож, бусдад тийн сургавал тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх болно. Харин хэн боловч тэдгээрийг сахьж, сургавал тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэх болно. ²⁰Би та нарт хэлье, хэрэв та нарын зөвт байдал чинь фарисайчууд болон хуулийн багш нараас илүү гарахгүй л бол, та нар тэнгэрийн хаанчлалд орохгүй.

²¹"Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч шийтгүүлбэл зохино" гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. ²²Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай. Ах дүүгээ "Хоосон толгой" гэж хэлсэн хэн боловч зөвлөлийн өмнө буруутай. "Мунхаг" гэж хэлсэн хэн боловч галтай тамд ороход хангалттай буруутгагдах болно. ²³Иймээс, хэрэв чи тахилын ширээнд өргөл өргөх гэж байхдаа чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь байгааг санавал, ²⁴өргөлөө тахилын ширээний өмнө орхиод замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө. ²⁵Замд хамт яваа дээрээ арцалдагчтайгаа аль болохоор түргэн сайдах хэрэгтэй. Эс тэгвэл арцалдагч хүн чинь чамайг шүүгчид өгч, шүүгч түшмэдэд хүргэж, чи шоронд хаягдах вий. ²⁶Үнэнээр Би чамд хэлье, чи эцсийн кодрантыг төлтлөө тэндээс гарахгүй.

²⁷"Завхайрч болохгүй" гэснийг та нар дуулсан. ²⁸Харин Би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм. ²⁹Хэрэв баруун нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж аваад хая. Учир нь чиний бүтэн бие тамд хаягдсанаас биеийн чинь нэг эрхтэн байхгүй байх нь чамд дээр. ³⁰Хэрэв баруун гар чинь чамайг

бүдрүүлбэл, тастаж хая. Учир нь чиний бүтэн бие тамд хаягдсанаас биеийн чинь нэг эрхтэн байхгүй байх нь чамд дээр. ³¹Мөн "Хэн боловч эхнэрээсээ салбал салалтыг гэрчилсэн бичиг түүнд өг" гэж хэлсэн байдаг. ³²Харин Би та нарт хэлье, хэн боловч садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салбал эхнэрээ завхайруулж буй хэрэг бөгөөд хэн боловч салсан эмэгтэйтэй гэрлэвэл завхайрч буй хэрэг мөн.

³³Эртний хүмүүст "Хуурамчаар бүү тангарагла, харин ЭЗЭНд амласнаа биелүүл" гэж хэлснийг та нар мөн сонссон. ³⁴Харин Би та нарт хэлье. Юугаар ч бүү тангарагла. Тэнгэрээр ч болохгүй, учир нь энэ нь Бурханы сэнтий юм. ³⁵Газраар ч болохгүй, учир нь энэ нь Түүний хөлийн гишгүүр юм. Иерусалимаар ч болохгүй, учир нь энэ бол агуу их Хааны хот юм. ³⁶Толгойгоороо ч чи тангараглаж болохгүй, учир нь чи ширхэг үсийг ч цагаан юмуу хар болгож үл чадна. ³⁷Харин үг чинь "За, за" эсвэл "Үгүй, үгүй" байг. Эдгээрээс цааших нь муугаас гардаг хэрэг юм.

³⁸«Нүдийг нүдээр, шүдийг шүдээр» гэснийг та нар дуулсан. ³⁹Харин Би та нарт хэлье, хар санаатай хүнийг бүү эсэргүүц. Харин хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа бас тавьж өг. ⁴⁰Хэрэв хэн нэг хүн чамтай заалдаж, цамцыг чинь авахыг хүсвэл дээлээ бас түүнд өг. ⁴¹Хэн нэг хүн чамайг нэг бээр газар явахыг хүчилбэл түүнтэй хамт хоёр бээр яв. ⁴²Чамаас гуйсан хүнд өг, чамаас зээлэхийг хүссэн хүнээс бүү зайлсхий.

⁴³"Хөршөө хайрла, дайснаа үзэн яд" гэж хэлснийг та нар сонссон. ⁴⁴Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир. ⁴⁵Тэгснээрээ та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд болно. Учир нь Тэр Өөрийнхөө нарыг хорон муу болоод сайн хүмүүс дээр мандуулж, зөвт болоод зөвт бус хүмүүс дээр бороо оруулдаг юм. ⁴⁶Хэрэв та нар өөрсдийг чинь хайрладаг хүмүүсийг хайрлавал, та нарт ямар шагнал байх вэ? Татвар хураагчид ч хүртэл үүнтэй адилыг хийдэг бус уу? ⁴⁷Хэрэв та нар зөвхөн ах дүүстэйгээ мэндэлбэл, бусдаас илүү юу хийж байгаа юм бэ? Харь үндэстнүүд ч хүртэл мөн ингэдэг бус уу? ⁴⁸Тиймээс тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг та нар мөн төгс бай.

[6]

¹Та нар хүмүүст харуулахын тулд тэдний өмнө зөвт байдлаа үйлдэхээс сэрэмжлэгтүн. Эс тэгвээс тэнгэр дэх Эцэгээс тань та нарт шагнал олдохгүй.

²Тиймээс та нар өглөг өгөхдөө, хүмүүсээр хүндлүүлэхийн тулд синагогт ба гудамжинд хоёр нүүрт хүмүүсийн үйлддэгтэй адил өөрсдийн өмнө бүрээ бүү тат. Үнэнээр Би та нарт хэлье. Тэд шагналаа бүрэн авсан юм. ³Харин та нар өглөг өгөхдөө, баруун гарынхаа юу хийж буйг зүүн гартаа бүү мэдэгд. ⁴Энэ нь өглөг чинь нууц байхын тулд бөгөөд нууцаар харагч Эцэг чинь чамд буцааж төлнө.

⁵Залбирахдаа хоёр нүүрт хүмүүс шиг байж болохгүй. Учир нь тэд хүмүүст харагдахын тулд синагогт ба гудамжны буланд зогсоод залбирах дуртай аж. Үнэнээр Би та нарт хэлье, тэд шагналаа бүрэн авсан юм. ⁶Харин чи залбирахдаа дотоод өрөөндөө орж хаалгаа хаагаад, нууцаар оршигч Эцэгтээ залбир. Нууцаар харагч Эцэг чинь чамд буцааж төлнө. ⁷Залбиран байхдаа харь үндэстнүүд шиг утгагүй хоосон үг бүү давт. Тэд нар олон үг хэлснийх нь төлөө Бурхан өөрсдийг нь сонсоно хэмээн боддог юм. ⁸Тиймээс тэдэн шиг байж болохгүй. Эцэг тань та нарт юу хэрэгтэй байгааг гуйхаас чинь өмнө мэддэг. ⁹Тиймд ийнхүү залбир.

"Тэнгэрт байгаа бидний Эцэг минь,
Таны нэр ариунаар дуурсгагдаг.

¹⁰Таны хаанчлал ирэх болтугай.

Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай.

¹¹Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч.

¹²Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач.

¹³Биднийг сорилтод бүү оруулаач,

Харин бузар муугаас гэтэлгээч.

[Учир нь хаанчлал, хүч чадал, алдар сүр үүрд Таных. Амен]"

¹⁴Учир нь, хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна. ¹⁵Харин хэрэв та нар хүмүүсийг уучлахгүй бол Эцэг тань мөн та нарын алдааг уучлахгүй.

¹⁶Чи мацаг барихдаа хоёр нүүрт хүмүүс шиг бүү баргар царайл. Учир нь тэд мацаг барьж байгаагаа хүмүүст харуулахын тулд нүүр царайгаа барайлгадаг байна. Үнэнээр Би та нарт хэлье, тэд шагналаа бүрэн авсан юм.

¹⁷Харин та нар мацаг барихдаа толгойгоо тослоод, нүүрээ угаа. ¹⁸Ингэснээр та нар мацаг барьж байгаагаа хүмүүст харуулахгүй, харин нууцаар оршигч Эцэгтээ харуулна. Тэгээд нууцаар хардаг Эцэг тань та нарт буцааж төлнө.

¹⁹Газар дээр өөрсөддөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. ²⁰Харин тэнгэрт эд баялгийг өөрсөддөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. ²¹Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно. ²²Нүд бол биеийн дэнлүү мөн. Хэрэв нүд чинь цэвэр бол бүтэн бие чинь гэрлээр дүүрэн байх болно. ²³Харин нүд чинь муу бол бүтэн бие чинь харанхуйгаар дүүрэн байх болно. Иймд хэрэв чиний доторх гэрэл нь харанхуй байх юм бол, тэрхүү харанхуй нь юутай их вэ! ²⁴Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан болоод эд баялагт хоёуланд нь зэрэг үйлчилж чадахгүй. ²⁵Ийм учраас Би та нарт хэлье. Амийнхаа төлөө юу идэх билээ, юу уух билээ гэж бүү санаа зов. Биеийнхээ төлөө юу өмсөх билээ гэж ч бүү санаа зов. Амь нь хоолноос, бие нь хувцаснаас илүү биш үү? ²⁶Тэнгэрийн шувуудыг хар. Тэд тариа тарьж ч, хурааж ч, саравчинд хадгалдаг ч үгүй боловч тэнгэрлэг Эцэг тань тэднийг тэжээдэг юм. Та нар тэднээс үлэмж илүү үнэ цэнэтэй биш үү? ²⁷Та нараас хэн чинь санаа зовсноороо өөрийнхөө өндрийг ганц тохойгоор нэмж чадах вэ? ²⁸Та нар юунд хувцас хунарт санаа зовно вэ? Талын сараана цэцэг хэрхэн ургаж буйг ажиглаач. Тэд ажил хийдэггүй, утас ч ээрдэггүй. ²⁹Гэвч Би та нарт хэлье. Соломон хаан ч сүр жавхлантай байхдаа эдгээр цэцэгсийн аль нэг шиг хувцаслаагүй юм. ³⁰Өнөөдөр ургаж, маргааш зууханд хаягдах хээрийн өвсийг Бурхан ийнхүү гоёдог бол, та нарын төлөө Тэр түүнээс хавьгүй илүүг хийхгүй гэж үү, итгэл багатай хүмүүс ээ? ³¹Тиймээс "Бид юу идэх билээ?", "Юу уух билээ?", эсвэл "Юу өмсөх билээ" гэж бүү санаа зов. ³²Харь үндэстнүүд энэ бүх зүйлсийг чармайн хайдаг. Тэнгэрлэг Эцэг тань та нарт энэ бүхэн хэрэгтэйг мэддэг юм. ³³Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно. ³⁴Тиймээс маргаашийн төлөө бүү санаа зов. Учир нь маргааш маргаашдаа санаа тавих болно. Өдөр бүрийн зовлон тухайн өдөртөө хангалттай.

[7]

¹Шүүгдэхгүйн тулд чи бүү шүү. ²Учир нь та нар яаж шүүнэ, түүнчлэн шүүгдэнэ. Та нарын хэмжүүрийн жишиг өөрсдийг чинь хэмжинэ. ³Чи ах дүүсийнхээ нүдэн дэх үртсийг хардаг атал яагаад өөрийн нүдэн дэх дүнзийг анзаардаггүй юм бэ? ⁴Эсвэл, өөрийн чинь нүдэнд дүнз байх атал ах дүүстээ

"Нүднээс чинь тэр үртсийг аваад өгье" гэж хэлнэ гэж үү? ⁵Хоёр нүүрт хүн чи, эхлээд нүднээсээ дүнзээ авч хая, тэгвэл чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхдаа сайн харах болно.

⁶Ариун юмыг нохдод бүү өг. Өөрсдийн сувдыг гахайны өмнө бүү хая. Тэд түүнийг хөл дороо гишгэчихээд, эргэж чамайг хэсэглэн тастчих вий.

⁷Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. ⁸Гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ. ⁹Хүүгээ талх гуйхад чулуу өгдөг хүн та нарын дунд байна уу? ¹⁰Эсвэл, загас гуйхад нь түүнд могой өгөхгүй биз дээ? ¹¹Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэнгэр дэх Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст илүү сайныг өгөх нь дамжиггүй бус уу? ¹²Тиймээс та нар хүмүүсийг өөрсөддөө хэрхэн хандаасай гэж хүссэнээрээ л өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд. Энэ бол Хууль болоод Эш үзүүлэгчид мөн.

¹³Нарийн хаалгаар ор. Учир нь сүйрэл уруу татан оруулдаг хаалга нь өргөн, зам нь уужим юм. Олон хүн түүгээр тийшээ ордог. ¹⁴Амь уруу хөтөлдөг хаалга нь жижиг, зам нь нарийн юм. Цөөхөн хүн түүнийг олдог.

¹⁵Хуурамч эш үзүүлэгчдээс болгоомжлогтун. Тэд хонины арьс нөмрөн та нар уруу ирэх боловч дотроо хомхой чононууд юм. ¹⁶Та нар тэднийг үр жимсээр нь танина. Өргөст бутнаас усан үзэм, халгайнаас инжир хураадаггүй биз дээ? ¹⁷Үүнчлэн сайн мод бүрээс сайн үр жимс ургадаг. Харин муу модноос муу үр жимс ургадаг. ¹⁸Сайн мод муу үр жимс ургуулж үл чадна, муу мод ч сайн үр жимс ургуулж үл чадна. ¹⁹Сайн үр жимс ургуулдаггүй аливаа модыг огтолж галд хаядаг. ²⁰Ийнхүү та нар тэднийг үр жимсээр нь танина. ²¹Намайг "Эзэн минь, Эзэн минь" гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. ²²Тэр өдөр Надад олон хүн "Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?" гэж хэлэх болно. ²³Тэгэхэд нь Би тэдэнд "Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл" гэж хэлнэ.

²⁴Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ. ²⁵Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. ²⁶Эдгээр үгсийг минь сонсоод,

үүний дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. ²⁷Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа гэв.

²⁸Тэгээд Есүсийг үгээ хэлж гүйцмэгц олон түмэн Түүний сургаалыг гайхан шагширч байлаа. ²⁹Тэр хуулийн багш нар шиг нь бус, эрх мэдэлтэй нэгэн шиг тэдэнд зааж байв.

[8]

¹Есүсийг уулаас бууж ирэхэд асар олон хүн Түүнийг дагав. ²Уяман өвчтэй нэгэн хүн Түүн дээр ирээд, өмнө нь сөгдөж,

—Эзэн минь, хэрэв Та хүсвэл намайг цэвэр болгож чадна шүү дээ гэхэд,

³Есүс гараа сунган түүнд хүрч

—Хүсэж байна. Цэвэрш гэв. Тэр даруй түүний уяман өвчин нь цэвэршжээ. ⁴Есүс түүнд

—Үүнийг хэнд ч хэлж болохгүй! Харин явж, өөрийгөө тахилчид үзүүлээд, тэдэнд гэрчлэхийн тулд Мосегийн тогтоосон өргөлийг өргө гэлээ.

⁵Есүсийг Капернаумд ороход нь нэгэн зуутын дарга Түүн дээр ирээд, Түүнээс гуйж,

— ⁶Эзэн, зарц маань саа өвчин тусаад, гэртээ хэвтэж, сүрхий өвдөн шаналж байна гэхэд ⁷Есүс

—Би очиж, түүнийг эдгээе гэж хэлэв. ⁸Харин зуутын дарга

—Эзэн, би Таныг гэртээ аваачих зохистой хүн биш ээ. Харин үг хэлээч, тэгвэл зарц маань эдгэрнэ. ⁹Би ч мөн эрх мэдэл дор байдаг хүн. Миний дор цэргүүд бий. Би нэгэнд нь "Яв" гэхэд тэр явдаг, нөгөөд нь "Ир" гэхэд тэр ирдэг. Боолдоо "Үүнийг хий" гэхэд тэр хийдэг гэж хариулав. ¹⁰Есүс үүнийг сонсоод ихэд гайхаж, дагаж явсан хүмүүст

—Үнэнээр Би та нарт хэлье. Би ийм агуу итгэлийг Израильд хэнээс ч олоогүй юм байна. ¹¹Та нарт Би хэлье. Дорноос хийгээд өрнөөс олон хүн ирж тэнгэрийн хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд сууна. ¹²Харин хаанчлалын хөвгүүд гаднах харанхуйд хаягдаж, тэндээ уйлж, шүдээ хавирах болно гэв. ¹³Тэгээд Есүс зуутын даргад

—Замаараа яв. Чиний итгэсэнчлэн болог гэхэд яг тэр цагт зарц нь эдгэрчээ.

¹⁴Есүс Петрийн гэрт очиж, хадам эхийг нь халуунтай өвдөн хэвтэж байхыг харав. ¹⁵Есүс түүний гарт хүрэхэд халуун нь арилан, тэр босоод Түүнд үйлчлэв. ¹⁶Орой болоход тэд чөтгөр шүглэсэн олон хүнийг Түүн уруу авчрахад, Есүс сүнснүүдийг үгээр хөөн зайлуулж, өвдсөн бүгдийг эдгээжээ. ¹⁷Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар «Бидний сул дорой байдлыг Тэр Өөртөө авч, бидний өвчнийг үүрсэн» гэж хэлүүлсэн нь биелэхийн тулд байлаа.

¹⁸Есүс олон хүн Өөрийг нь тойрсныг хараад, нуурын нөгөө тал уруу явахыг тушаав. ¹⁹Нэгэн хуулийн багш ирж, Түүнд

—Багш аа, Таныг хаашаа ч явсан би дагаж явъя гэв. ²⁰Есүс

—Үнэг нүхтэй, тэнгэрийн шувууд үүртэй байдаг. Харин Хүний Хүүд толгой хоргодох газар байхгүй гэлээ. ²¹Дагалдагчдын нэг нь Түүнд

—Эзэн, эхлээд явж, эцгийгээ оршуулахыг минь надад зөвшөөрөөч гэсэнд ²²Есүс

—Намайг дага. Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул гэв.

²³Түүнийг завинд суухад шавь нар нь Түүнийг дагалаа. ²⁴Үзэгтүн. Нуурт маш хүчтэй шуурга босож, завь давалгаанд автсан боловч Есүс унтаж байлаа. ²⁵Тэд Түүн уруу ирж, Түүнийг сэрээгээд

—Эзэн минь, авраач, бид сүйрлээ гэхэд нь, ²⁶Есүс тэдэнд

—Юунд айцгаана вэ, итгэл багатай хүмүүсээ? гээд, Тэр босож, салхи болоод нуурыг зэмлэжээ. Гэтэл нам гүм боллоо. ²⁷Хүмүүс гайхаж

—Энэ ер нь ямар янзын хүн болоод салхи, нуур хүртэл Түүнд захирагдаж байгаа юм бэ? гэлцэв.

²⁸Түүнийг нуурын нөгөө талд гадарчуудын нутагт ирэхэд булшнуудын тэндээс чөтгөрт эзлэгдсэн хоёр хүн гарч ирээд, Түүнтэй тааралдав. Тэд их хэрцгий догшин тул тэр замаар нэг ч хүн явж зүрхэлдэггүй байжээ.

²⁹Үзэгтүн, тэд хашхиран,

—Бурханы Хүү, бид Танд ямар хамаатай билээ? Цагаас маань өмнө биднийг тарчилгахаар Та энд ирэв үү? гэв. ³⁰Тэнд тэднээс зайдуухан сүрэг гахай идээшилж байлаа. ³¹Чөтгөрүүд Түүнээс гуйж

—Хэрэв Та биднийг хөөж гаргах гэж байгаа бол биднийг сүрэг гахайнд оруулаач гэв. ³²Тэр

—Зайлцгаа гэхэд, сүнснүүд гарч гахайнуудад шүглэхэд, гахайн сүрэг бултаараа нуурын эгц эрэг уруу давхилдан орж усанд живж, үхжээ. ³³Гахайчид зугтан хот уруу орж, болсон явдал болоод чөтгөрт эзэмдүүлж байсан хүмүүсийн тухай мэдүүлэв. ³⁴Хотынхон бүгдээрээ Есүстэй уулзахаар ирж, Түүнийг үзээд нутгаасаа явахыг гуйв.

[9]

¹ Тэр завинд сууж, гатлан явсаар Өөрийн хотдоо ирлээ. ² Хүмүүс саа өвчтэй нэгэн хүнийг дэвсгэртэй нь Түүн уруу авчрахад, Есүс тэдний итгэлийг хараад, саа өвчтэй хүнд

—Хүү минь, зоригтой бай. Нүгэл чинь уучлагдсан гэв. ³ Хуулийн багш нарын зарим нь

—Энэ хүн Бурханыг доромжилж байна хэмээн боджээ. ⁴ Есүс тэдний бодлыг мэдээд,

—Та нар зүрх сэтгэлдээ юунд бузар мууг бодно вэ? ⁵ "Нүгэл чинь уучлагдсан" гэж хэлэх, эсвэл "Босоод алх" гэж хэлэхийн аль нь амархан бэ? ⁶ Харин Хүний Хүү газар дээр нүглийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд, Тэрээр саа өвчтэй хүнд

—Бос, дэвсгэрээ аваад, гэртээ харь гэсэнд, ⁷ мөнөөх хүн босож гэрийн зүг явлаа. ⁸ Харин олон түмэн үүнийг хараад, айн сүрдэж, хүнд ийм эрх мэдэл өгсөн Бурханыг алдаршуулав.

⁹ Есүс тэндээс гарч өнгөрөхдөө татварын газар Матай гэгч хүний сууж байхыг харав. Тэр түүнд

—Намайг дага гэхэд тэр босож, Түүнийг дагалаа.

¹⁰ Есүсийг айлд ширээнд тухлан байтал олон татвар хураагчид, нүгэлтнүүд ирээд, Есүс болон Түүний шавь нартай хамт идэж байв.

¹¹ Үүнийг харсан фарисайчууд Түүний шавь нарт

—Яагаад танай багш татвар хураагчид болон нүгэлтнүүдтэй хамт хооллож байдаг билээ? гэжээ. ¹² Харин Есүс үүнийг сонсоод

—Эмч эрүүл хүмүүст бус, өвчтэй хүмүүст хэрэгтэй. ¹³ Харин явж, "Би тахилыг бус, энэрлийг хүсдэг" гэсэн нь ямар учиртайг мэд. Учир нь Би зөвт хүмүүсийг бус, харин нүгэлтнүүдийг дуудахаар ирсэн юм гэв.

¹⁴ Дараа нь Иоханы шавь нар Түүн дээр ирж,

—Яагаад фарисайчууд болоод бид мацаг барьдаг, харин Таны шавь нар мацаг барьдаггүй юм бэ? гэж асуухад, ¹⁵Есүс тэдэнд хэлсэн нь

—Шинэ хүргэний бараа бологчид хүргэнтэйгээ хамт байхдаа гашуудаж болохгүй биз дээ? Гэвч хүргэн тэднээс аваачигдах өдрүүд ирнэ. Тэгэхэд тэд мацаг барина. ¹⁶Ер нь хэн ч хуучин дээлэн дээр агчаагүй даавуугаар нөхөөс тавихгүй. Тэгвэл нөхөөс дээлийг таталдуулж бүр ихээр урна. ¹⁷Хүмүүс шинэ дарсыг хуучин тулманд хийдэггүй. Тэгвээс тулам сад тавьж, дарс асгарч, тулам хэрэггүй болно. Харин тэд шинэ дарсыг шинэ тулманд хийвэл аль аль нь хэвээрээ байх болно.

¹⁸Есүс тэдэнд эдгээрийг ярьж байх зуур, тэнд нэгэн захирагч ирж, Түүний өмнө мөргөөд,

—Миний охин дөнгөж саяхан үхчихлээ. Харин Та очиж түүнд гар хүрвэл охин минь амьдрах болно гэжээ. ¹⁹Есүс босож, түүнийг даган явахад шавь нар нь ч бас хамт явлаа. ²⁰Гэтэл арван хоёр жилийн турш цус алддаг өвчтэй байсан нэгэн эмэгтэй Түүний ард ирж, дээлийнх нь хормойд гар хүрсэн агаад ²¹ингэхдээ тэр эмэгтэй

—Хэрэв Түүний дээлд нь л хүрвэл би эдгэнэ гэж өөртөө үглэн байжээ. ²²Харин Есүс эргэнгээ мөнөөх эмэгтэйг хараад

—Охин минь, зоригтой бай. Итгэл чинь чамайг эдгээлээ гэлээ. Тэр даруй эмэгтэй эдгэрчээ. ²³Тэгээд Есүс захирагчийн гэрт очоод, бишгүүрчдийг болон дуу шуу болсон олныг харж,

— ²⁴Гарцгаа. Охин үхээгүй, харин унтаж байна гэхэд тэд Түүнийг шоолон инээлджээ. ²⁵Тэднийг гарсны дараа Есүс дотогш орж, охины гараас барихад охин босов. ²⁶Энэ зар тэр нутаг даяар таржээ.

²⁷Есүс тэндээс цааш явж байтал хоёр сохор хүн

—Давидын Хүү минь ээ. Биднийг энэрээч гэж хашхиран, Түүнийг дагажээ. ²⁸Айлд орсных нь дараа, сохор хүмүүс Түүн уруу ирэхэд Есүс тэдэнд

—Намайг үүнийг хийж чадна гэж та нар итгэж байна уу? гэж асуухад тэд

—Тийм ээ, Эзэн гэв. ²⁹Тэгээд Есүс тэдний нүдэнд гар хүрч,

—Итгэлийн тань дагуу болог гэсэнд ³⁰тэд хараа оржээ. Есүс тэдэнд

—Хэн ч үүнийг мэдэж болохгүйг анхаар гэж хатуу сануулав. ³¹Гэвч тэд гараад, Түүний тухай зарыг тэр нутаг даяар тараалаа.

³²Тэднийг гарч явмагц, чөтгөрт эзэмдүүлсэн хэлгүй хүнийг Түүн дээр авчрав. ³³Чөтгөр нь зайлуулагдсаны дараа мөнөөх хэлгүй хүн ярихад олон түмэн гайхаж,

—Израильд ийм юм хэзээ ч үзэгдэж байгаагүй гэгцгээв. ³⁴Харин фарисайчууд

—Тэр чөтгөрүүдийн захирагчаар нь чөтгөрүүдийг хөөдөг юм байна гэж ярьж байлаа.

³⁵Есүс синагогуудад сургаал айлдаж, хаанчлалын сайн мэдээг тунхаглан, бүх төрлийн өвчин эмгэгийг эдгээн, бүх хот тосгоноор явж байлаа.

³⁶Хүмүүсийг хараад Тэр өрөвджээ. Учир нь тэд хоньчингүй хонин сүрэг мэт тарж, туйлдсан байлаа. ³⁷Тэгээд Тэр шавь нартаа

—Ургац үнэндээ арвин боловч ажилчид нь цөөн байна. ³⁸Тиймээс ургацын Эзэнээс ургацандаа ажилчдыг явуулахыг залбиран гуйцгаа гэж айлдав.

[10]

¹Есүс арван хоёр шавиа дуудаад, тэдэнд бузар сүнснүүдийг захирах эрх мэдлийг өгсөн нь сүнснүүдийг зайлуулах, бүх төрлийн өвчин эмгэгийг эдгээхийн тулд ажээ. ²Арван хоёр элч нарын нэрс нь гэвэл: эхлээд Петр гэгддэг Симон, түүний дүү Андрей, Зебедеен хүү Иаков, түүний дүү Иохан, ³Филип, Бартоломай, Томас, татвар хураагч Матай, Алфайн хүү Иаков, Таддай, ⁴Зеалотын Симон болон Искаротын, Есүсээс урвасан Иудас болой.

⁵Есүс эдгээр арван хоёрыг явуулахдаа тэдэнд ингэж сургамжилжээ.

—Харь үндэстнүүдийн замаар бүү яв. Самаричуудын ямар ч хотод бүү оч. ⁶Харин Израилийн гэрийн төөрсөн хонинууд уруу оч. ⁷Та нар явахдаа "Тэнгэрийн хаанчлал ойрхон байна" гэж тунхаглагтун, ⁸Өвчнийг эдгээ, үхэгсдийг босго, уяман өвчтөнг цэвэрлэ, чөтгөрийг зайлуул. Үнэгүйгээр авснаа үнэгүйгээр өг. ⁹Бүсэндээ алт ч, мөнгө ч, зэс ч гэсэн авч явж болохгүй. ¹⁰Аяны богц ч, хос дээл ч, гутал ч, таяг ч гэсэн бүү ав. Учир нь ажилчин нь хоол хүнсээр хангагдах нь зохистой. ¹¹Ямар ч хот тосгонд очсон, тэндхийн зохистой хүнийг олж мэдээд явтлаа тэндээ бай. ¹²Айлд

орохдоо мэндийг нь мэд. ¹³Хэрэв тэр айл чинь зохистой бол, амар амгалангийн мэнд чинь тэдэнд хүрэг. Хэрэв зохисгүй бол, амар амгалангийн мэнд чинь та нарт буцаж ирэг. ¹⁴Хэн та нарыг хүлээн авалгүй, үгийг чинь үл ойшоох аваас, тэр айлаас эсвэл хотоос гарахдаа та нар хөлийнхөө тоосыг сэгсрэн унага. ¹⁵Үнэнээр Би та нарт хэлье, шүүлтийн өдөр Содом ба Гоморрагийн газар нь тэр хотоос илүү тэвчмээр байх болно.

¹⁶Харагтун, Би та нарыг сүрэг чонон дундах хонь мэт илгээж байна. Тиймээс та нар могой шиг хурц ухаантай, тагтаа шиг гэмгүй бай. ¹⁷Харин хүмүүсээс болгоомжил. Учир нь тэд та нарыг шүүхэд тушааж, синагогууд дотроо та нарыг ташуурдах болно. ¹⁸Та нар тэдэнд болоод харь үндэстнүүдэд гэрчлэл болж Миний төлөө захирагчид болон хаадын өмнө хүргэгдэх болно. ¹⁹Тэд та нарыг баривчлах үед яах билээ, юу хэлэх билээ гэж бүү санаа зов. Учир нь хэлэх зүйл чинь тэр цагт та нарт өгөгдөнө. ²⁰Яригч бол та нар бус, та нарын дотор яригч Эцэгийн чинь Сүнс юм. ²¹Ах нь дүүгээ, эцэг нь хүүгээ үхэлд тушаана. Хүүхдүүд нь эцэг эхийнхээ эсрэг босож, тэднийг үхэлд хүргэнэ. ²²Миний нэрээс болж бүгд та нарыг үзэн ядна. Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдах болно. ²³Харин тэд та нарыг энэ хотод хавчвал, өөр хот уруу зугтацгаа. Үнэнээр Би та нарт хэлье. Хүний Хүүг ирэхээс нааш та нар Израилийн хотуудаар явж барахгүй.

²⁴Шавь нь багшаасаа, боол нь эзнээсээ дээр байдаггүй. ²⁵Шавь нь багшийнхаа адил, боол нь эзнийхээ адил болох нь л хангалттай. Хэрэв тэд гэрийн тэргүүнийг Беелзебул хэмээн нэрлэсэн бол, гэрийнхнийг нь түүнээс ч илүүгээр хэлэх бус уу? ²⁶Иймээс тэднээс бүү ай. Илчлэгдэхгүй байхаар далдлагдсан, мэдэгдэхгүй байхаар нуугдсан юм гэж байхгүй билээ. ²⁷Харанхуйд та нарт юу хэлснийг минь гэрэлд ярь, чихэнд чинь шивнэснийг минь сонссоноо дээвэр дээр тунхагла. ²⁸Биеийг хөнөөх хүмүүсээс бүү ай. Учир нь тэд сэтгэлийг хөнөөж үл чадна. Харин махан бие болоод сэтгэлийг, хоёуланг нь тамд устгаж чадах Түүнээс айгтун. ²⁹Хоёр бор шувууг задгай зоосоор худалддаг биш үү? Эцэгийн тань зөвшөөрөлгүйгээр тэдний нэг нь ч газарт унахгүй. ³⁰Та нарын толгой дээрх ширхэг үсийг чинь хүртэл бүгдийг нь тоолсон байна. ³¹Иймээс бүү ай; та нар олон бор шувуунаас ч илүү үнэтэй. ³²Тиймээс Намайг хүмүүсийн өмнө хүлээн зөвшөөрсөн хүн бүрийг Би тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө мөн хүлээн зөвшөөрнө. ³³Харин Намайг хүмүүсийн өмнө үгүйсгэсэн хэнийг ч болов Би тэнгэр дэх Эцэгийнхээ өмнө үгүйсгэнэ.

³⁴Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм. ³⁵Би хүүг эцгийнх нь эсрэг, охиныг эхийнх нь эсрэг, бэрийг хадмынх нь эсрэг болгохоор ирсэн. ³⁶Хүний дайсан нь өөрийнх нь гэр бүлийнхэн нь болно. ³⁷Эцгийгээ, эсвэл эхийгээ Надаас илүү хайрладаг хүн Миний хувьд зохистой нэгэн биш юм. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрладаг хүн ч Миний хувьд зохистой нэгэн бишээ. ³⁸Загалмайгаа үүрээд Миний хойноос дагахгүй хүн Миний хувьд зохистой нэгэн биш. ³⁹Амиа ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно.

⁴⁰Та нарыг хүлээн авсан хүн Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авсан хүн Намайг илгээсэн Түүнийг хүлээн авсан хэрэг юм. ⁴¹Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүлээн авах хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. ⁴²Үнэнээр Би та нарт хэлье. Эдгээр өчүүхэн хүмүүсийн нэгэнд шавийн нэрээр уух аяга хүйтэн ус өгсөн хэн боловч шагналаа үл алдана гэв.

[11]

¹Есүс арван хоёр шавь нараа сургамжилж дуусаад, тэдний хотуудаар сургаал айлдан, номлохоор тэндээс явав.

²Иохан шоронд байхдаа Христийн үйлсийг сонсоод, өөрийн шавь нараар үг дайж, ³Түүнээс

—Та ирэх ёстой Нэгэн мөн үү, эсвэл бид өөр нэгнийг хүлээх юм уу? гэж асуулгав. ⁴Есүс хариуд нь тэдэнд

—Явж, үзсэн дуулснаа Иоханд хэл. ⁵Сохор нь хараа орж, суунги нь алхаж, уяман өвчтөнүүд нь цэвэршиж, дүлий нь сонсож, үхэгсэд нь амилж, ядууст сайн мэдээ тунхаглагдаж байна. ⁶Надаас болж бүдрээгүй нэг нь ерөөлтэй еэ гэв. ⁷Тэднийг явмагц Есүс олон түмэнд Иоханы тухай ярьж эхлэв.

—Та нар юу харах гэж цөл уруу очсон бэ? Салхинд найгах зэгсийг үү? ⁸Тэгвэл та нар юу харах гэж очив? Үзэгтүн. Хээнцэр хувцасласан хүнийг үү? Хээнцэр хувцасласан хүмүүс хааны ордонд байдаг шүү дээ. ⁹Тэгэхээр юунд та нар тийшээ очсон хэрэг вэ? Эш үзүүлэгчийг харах гэж үү? Тийм ээ. Би та нарт хэлье, эш үзүүлэгчээс ч илүү нэгнийг юм. ¹⁰Түүний тухай

"Харагтун, Би Чиний өмнө элчээ илгээнэ.
Тэр элч Чиний өмнөх замыг чинь бэлтгэнэ"

гэж бичигдсэн юм. ¹¹Үнэнээр Би та нарт хэлье. Эмэгтэй хүнээс төрсөн хүмүүсийн дунд баптисм хүртээгч Иоханаас илүү агуу байгаагүй. Харин тэнгэрийн хаанчлалын хамгийн бага нэгэн ч түүнээс агуу билээ. ¹²Баптисм хүртээгч Иоханы өдрүүдээс өнөөг хүртэл тэнгэрийн хаанчлал хүчинд автаж байна. Хүчирхийлэгч хүмүүс түүнийг хүчээр авдаг. ¹³Хууль болоод бүх эш үзүүлэгчид Иоханыг ирэх хүртэл эш үзүүлж байлаа. ¹⁴Хэрэв та нар үүнийг хүлээн авахыг хүсвэл тэр бол ирэх ёстой байсан Елиа мөн. ¹⁵Сонсох чихтэй нь сонсогтун. ¹⁶Харин энэ үеийнхнийг Би юутай зүйрлүүлэх вэ? Энэ нь зах дээр суугаад бусад хүүхдүүдийг дуудан байгаа хүүхдүүдтэй төстэй агаад тэд\v 17 "Бид та нарт зориулж бишгүүрдэхэд та нар бүжиглэсэнгүй. Бид гашуудлын дуу дуулахад та нар гашуудсангүй" гэж хэлдэг. ¹⁸Иохан идэх ч үгүй, уух ч үгүй ирэхэд тэд "Түүнд чөтгөр шүглэсэн байна" гэдэг. ¹⁹Хүний Хүүг ирээд идэж уухад тэд "Харцгаа. Ховдог, архичин, татвар хураагч болон нүгэлтнүүдийн анд нөхөр!" гэдэг. Гэсэн хэдий ч мэргэн ухаан нь үйлсээрээ зөвтгөгддөг гэв.

²⁰Тэгээд Тэр ихэнх гайхамшгуудаа үйлдсэн хотуудыг зэмлэж эхлэв. Учир нь тэд гэмшээгүй юм.

— ²¹Хоразин аа, чи золгүй еэ! Бетсайд аа, чи золгүй еэ! Хэрэв та нарт учирсан гайхамшгууд нь Тир, Сидонд тохиолдсон бол тэд аль эрт үнсэн дээр таар нөмрөөд гэмшсэн байхсан. ²²Харин Би та нарт хэлье. Шүүлтийн өдөр Тир болон Сидон нь та нараас илүү хүлцмээр байх болно. ²³Капернаум аа, чи тэнгэрт тултал өргөмжлөгдсөн байх уу? Чи Үхэгсдийн оронд унах болно. Хэрэв та нарт учирсан гайхамшгууд нь Содомд тохиолдсон бол тэр хот энэ өдрийг хүртэл үлдэх байсан. ²⁴Харин Би та нарт хэлье. Шүүлтийн өдөр Содомын газар чамаас илүү хүлцмээр байх болно гэлээ.

²⁵Тэр үед Есүс хариу болгон

—Тэнгэр газрын Эзэн, Эцэг минь ээ, Таныгаа Би магтъя. Та эдгээр зүйлсийг ухаант хүмүүс, мэргэдээс нууцалж балчир хүүхдүүдэд илчилсэн билээ. ²⁶Тийм ээ, Эцэг минь, ийнхүү энэ нь Таны өмнө тааламжтай байсан. ²⁷Эцэг минь бүгдийг Надад өгсөн бөгөөд Эцэгээс өөр хэн ч Хүүг танихгүй. Хүү болон Хүүгийн Эцэгээ илчлэхээр хүссэн хүнээс өөр хэн ч Эцэгийг танихгүй. ²⁸Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу

ир. Би та нарт амралтыг өгье. ²⁹Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. ³⁰Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн гэв.

[12]

¹Тухайн үед нэгэн амралтын өдөр, тариан талбайн дундуур Есүс явж байв. Шавь нар нь өлсгөлөн байсны улмаас тариан түрүүг шувтран идэж эхлэв. ²Гэтэл үүнийг фарисайчууд хараад, Түүнд

—Хараач, Таны шавь нар амралтын өдөр хууль бус юм үйлдэж байна гэцгээв. ³Харин Есүс тэдэнд хэлсэн нь

—Давид болон түүнтэй хамт байгсад нь өлссөн үедээ юу хийснийг та нар уншаагүй юу? ⁴Давид Бурханы гэрт орж, зөвхөн тахилч нараас өөр хэн ч идэж үл болох ариусгасан талхнаас тэр болон түүнтэй хамт байгсад нь идсэн шүү дээ. ⁵Амралтын өдөр тахилч нар сүм дотор Амралтын өдрийг зөрчсөн ч гэм зэмгүй гэснийг та нар Хуулиас уншаагүй гэж үү? ⁶Харин Би та нарт хэлье. Сүмээс илүү аугаа нэгэн энд байна. ⁷Хэрэв та нар "Би тахилыг бус, энэрлийг хүсдэг" гэсэн нь ямар утгатай болохыг ойлгосон бол гэмгүй хүнийг буруутгахгүй байх байсан. ⁸Учир нь Хүний Хүү нь Амралтын өдрийн Эзэн мөн.

⁹Есүс тэндээс явж, тэдний синагогт орлоо. ¹⁰Хатингар гартай нэгэн хүн тэнд байжээ. Тэд Есүсийг буруутгахаар

—Амралтын өдөр эдгээх нь хуульд нийцэх үү? гэж асуухад, ¹¹Тэр тэдэнд

—Хэрэв та нарын дундаас хэн нэгэн нь ганцхан хоньтой байгаад тэр нь Амралтын өдөр нүхэнд уначихвал, хонио барьж, тэндээс гаргана биз дээ? ¹²Тэгвэл хүн хониноос аль хир эрхэм билээ? Тиймээс Амралтын өдөр сайныг үйлдэх нь хуульд нийцнэ гээд, ¹³мөнөөх хүнд хандан

—Гараа сунга гэсэнд, тэр хүн сунгамагц гар нь нөгөө гарынхаа адил зүгээр болов. ¹⁴Харин фарисайчууд гарч, Түүнийг хэрхэн хөнөөх талаар хамтдаа Түүний эсрэг зөвлөлдөв.

¹⁵Харин Есүс үүнийг мэдэнгүүтээ тэндээс холдов. Түүнийг олон хүн дагаж байлаа. Тэр тэднийг бүгдийг нь эдгээгээд, ¹⁶Өөрийг нь мэдүүлж

болохгүйг тэдэнд сануулав. ¹⁷Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар хэлүүлсэн нь биелэгдэхийн тулд бөгөөд тэр ийн хэлсэн байна.

¹⁸«Миний сонгосон Зарц,
сэтгэлд минь нийцсэн Миний Хайртыг харагтун.
Би Түүний дээр Өөрийн Сүнсээ байлгана.
Тэр нь Харь үндэстэнд шударга ёсыг тунхаглах болно.

¹⁹Тэр мэтгэлцэхгүй, хашхирахгүй бөгөөд
Гудамжнуудад хэн ч Түүний дууг сонсохгүй.

²⁰Тэр шударга ёсыг ялалтад хүргэтэл
бяцлагдсан хулсыг хугалахгүй,
сүүмэлзэх зулыг ч бөхөөхгүй.

²¹Түүний нэрд Харь үндэстнүүд найдах болно».

²²Тэгээд Түүн уруу чөтгөрт эзэмдүүлсэн сохор, хэлгүй нэгнийг авчирсанд, Тэр түүнийг эдгээв. Тийнхүү хэлгүй эр ярьдаг, хардаг болжээ.

²³Олон түмэн бүгдээрээ ихэд гайхан,

—Энэ хүн чинь Давидын Хүү биш болов уу? гэцгээж эхлэв. ²⁴Харин фарисайчууд үүнийг сонсоод,

—Энэ хүн чинь зөвхөн чөтгөрүүдийн захирагч Беелзебулээр л чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг гэж хэлсэнд, ²⁵Есүс тэдний бодлыг мэдээд, тэдэнд хандан,

—Аливаа хаанчлал дотроо хуваагдвал сүйрнэ. Аливаа хот, эсвэл гэр дотроо хуваагдвал оршин тогтнохгүй. ²⁶Хэрэв Сатан нь Сатаныгаа зайлуулбал, тэр өөрийнхөө эсрэг хуваагдаж байгаа хэрэг болох нь. Тэгвэл түүний хаанчлал хэрхэн тогтнох билээ? ²⁷Хэрэв Би Беелзебулээр чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг юм бол, танай хөвгүүд хэнээр чөтгөрүүдийг зайлуулдаг байх вэ? Тэгэхээр тэд та нарын шүүгч болно. ²⁸Харин хэрвээ Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна. ²⁹Бяртай эрийг эхлээд хүлэхгүй бол хэн түүний гэрт нь ороод эд хөрөнгийг нь булааж чадах билээ? Хүлсний дараа л гэрийг нь дээрэмдэнэ шүү дээ. ³⁰Надтай хамт байдаггүй хүн Миний эсрэг байна. Надтай хамт хураалцдаггүй хүн бол тараагч нэгэн мөн. ³¹Тиймээс Би та нарт хэлье. Хүмүүсийн аливаа нүгэл хийгээд доромжлол нь уучлагдана. Харин Сүнсний эсрэг доромжлол уучлагдахгүй. ³²Хүний Хүүгийн эсрэг үг хэлдэг хэн боловч уучлагдах болно. Харин Ариун Сүнсний эсрэг ярьдаг хэн ч энэ үед ч, ирэх үед ч уучлагдахгүй. ³³Эсвэл мод нь сайн бол үр жимс нь

сайн, мод нь муу бол үр жимс нь муу ажээ. Учир нь модыг үр жимсээр нь таньдаг. ³⁴Хорт могойн удам аа! Та нар өөдгүй хорон атлаа сайныг ярьж яаж чадна вэ? Учир нь зүрхний бялхалаас ам ярьдаг. ³⁵Сайн хүн өөрийн сайн баялгаас сайныг гаргадаг, муу хүн өөрийн муу баялгаас мууг л гаргадаг. ³⁶Би та нарт хэлье. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно. ³⁷Учир нь чи үгсээрээ зөвтгөгдөнө, мөн чи үгсээрээ яллагдана гэв.

³⁸Тэгтэл хуулийн багш нар ба фарисайчуудын зарим нь Түүнд

—Багш аа, бид Танаас тэмдгийг үзэхийг хүсэж байна гэсэнд, ³⁹харин Тэр тэдэнд

—Хорон муу болоод завхай үеийнхэн тэмдгийг эрж хайдаг. Гэвч эш үзүүлэгч Ионагийн тэмдгээс өөр ямар ч тэмдгийг тэдэнд өгөхгүй. ⁴⁰Иона далайн мангасын гэдсэнд гурван өдөр, гурван шөнө байсанчлан Хүний Хүү газрын зүрхэнд гурван өдөр, гурван шөнө байх болно. ⁴¹Шүүлт дээр Ниневегийн хүмүүс энэ үеийнхэнтэй хамт босож, эднийг яллах болно. Учир нь тэд Ионагийн тунхаглалд гэмшсэн юм. Үзэгтүн, энд Ионагаас ч аугаа нэгэн байна. ⁴²Шүүлт дээр Өмнөдийн Хатан хаан энэ үеийнхэнтэй хамт босож эднийг яллах болно. Учир нь тэр Хатан хаан Соломоны мэргэн ухааныг сонсохоор газрын мухраас ирсэн билээ. Үзэгтүн, энд Соломоноос аугаа зүйл байна. ⁴³Бузар сүнс хүнээс гарахдаа, усгүй ангамал газраар хэрэн хэсэж амралтыг хайвч түүнийгээ олдоггүй. ⁴⁴Тэгээд тэр "Би хаанаас гарлаа, тэр гэртээ эргэж очъё" гэж хэлдэг. Буцаж ирэхэд нь, түүнийг хэн ч эзлээгүй бөгөөд шүүрдсэн, цэгцтэй болсон байхыг тэр хардаг. ⁴⁵Тэгээд тэр явж, өөрөөсөө дор өөр долоон сүнсний хамт тийшээ орж, тэндээ амьдардаг аж. Өнөөх хүний хувьд сүүлчийнх нь байдал анхныхаасаа бүр дорддог. Энэ муу үеийнхэн ч мөн тийм байх болно гэж айлдав.

⁴⁶Түүнийг хүмүүстэй ярьж байх зуур эх, дүү нар нь Түүнтэй ярилцахыг хүсэмжилж гадаа зогсож байлаа. ⁴⁷Хэн нэг нь Түүнд

—Хараач, эх, дүү нар тань Тантай ярилцахаар гадаа зогсож байна гэхэд, ⁴⁸Есүс харин тэр хүнд

—Хэн Миний эх, хэн Миний дүү нар юм бэ? гээд ⁴⁹Өөрийн шавь нарын зүг гараа сунгаад,

—Харагтун, эд бол Миний эх болоод ах дүүс. ⁵⁰Тэнгэр дэх Эцэгийн минь хүслийг биелүүлэгч хэн боловч Миний эх, ах эгч дүүс мөн гэж айлдав.

[13]

¹ Тэр өдөр Есүс гэрээс гарч, нуурын эрэг дээр сууж байлаа. ² Түүн дээр асар олон хүн хуран цугласан тул Тэр завин дээр гарч суужээ. Хурсан олон цөмөөрөө эрэг дээр зогсож байлаа. ³ Есүс тэдэнд олон зүйлийг сургаалт зүйрлэлээр айлдруун

—Харагтун. Тариачин үр суулгахаар гарчээ. ⁴Түүнийг үрээ цацахад зарим үр нь замын хавиар унасанд шувууд ирээд идчихлээ. ⁵Зарим нь чулуурхаг газар унаж, хөрс нь гүн биш тул тэр дороо соёолов. ⁶Гэвч нар гарахад үндэсгүй учир тэд хорчийн хатжээ. ⁷Зарим нь хогийн ургамлын дунд унав. Хогийн ургамал ургаж тэднийг барьчихаж. ⁸Зарим нь сайн хөрсөнд унаж ургаад, ургацаа өгөхөд зарим нь зуу, зарим нь жар, зарим нь гуч дахин их болов. ⁹Сонсох чихтэй нь сонсогтун гэв.

¹⁰Шавь нар нь Түүн уруу ирж,

—Та яагаад тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг юм бэ? гэхэд ¹¹Тэр

—Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн юм. Харин тэдэнд өгөгдөөгүй. ¹²Учир нь хэнд байна, түүнд ихээр өгөгдөж, элбэг дэлбэг байх болно. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс авагдана. ¹³Тэд харавч хардаггүй, сонсовч сонсдоггүй бөгөөд ойлгодог ч үгүй учир Би тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг. ¹⁴Тийм хүмүүс дээр Исаиагийн эш үзүүллэг биелдэг юм. Юу гэвэл тэр

"Та нар сонссоор, сонссоор байтал огт ухаарахгүй,
харсаар, харсаар байтал огт ойлгохгүй.

¹⁵Учир нь энэ ард түмний зүрх нь хатуурч,
чихээрээ дөнгөж сонсон, нүдээ аньжээ.

«Эс бөгөөс тэд нүдээрээ харж,
чихээрээ сонсож, зүрхээрээ ухаарч,
эргэж буцах байсан бөгөөд

Би тэднийг эдгээх байсан» гэсэн байдаг"

гэсэн юм. ¹⁶Харин та нарын нүд хардаг тул нүд чинь, та нарын чих сонсдог тул чих чинь ерөөлтэй еэ. ¹⁷Үнэнээр Би та нарт хэлье. Та нарын харж байгааг олон эш үзүүлэгч, зөвт хүмүүс харахыг хүссэн авч хараагүй, сонсож байгааг тань сонсохыг хүссэн авч сонсоогүй юм. ¹⁸Тиймээс тариачны сургаалт зүйрлэл ямар утгатай болохыг сонсогтун. ¹⁹Хэн нэг нь хаанчлалын тухай үгийг сонссон авч үл ойлговол хорон нэгэн нь ирж,

түүний зүрхэнд юу суулгагдсаныг булаан авдаг байна. Энэ нь зам хавиар унагсад юм. ²⁰Чулуурхаг газар унасан нь үгийг сонсоод тэр даруйдаа баяртайгаар хүлээн авч, ²¹харин өөрт нь бат үндэс байхгүй тул түр зуур байдаг аж. Үгнээс болж хавчлага, эсвэл зовлон тохиолдоход тэр дороо л унадаг. ²²Хогийн ургамлын дунд унасан нь үгийг сонсдог. Харин дэлхийн зовнил болоод эд баялгийн хуурамч байдал нь үгийг шахан зайлуулахад энэ нь үр жимсгүй болдог. ²³Сайн хөрсөнд унасан нь үгийг сонсдог ба ойлгодог нэгэн байх бөгөөд тэр нь үнэхээр үр жимс гаргадаг. Зарим нь зуу, зарим нь жар, зарим нь гуч дахинг авчрах болно гэж айлдав.

²⁴Есүс тэдэнд өөр сургаалт зүйрлэл айлдруун

—Тэнгэрийн хаанчлалыг талбайдаа сайн үр тарьсан хүнтэй зүйрлэж болох юм. ²⁵Хүмүүсийг унтаж байхад нь түүний дайсан ирж, буудайн дунд зэрлэг өвс тарьчихаад яваад өгчээ. ²⁶Түрүү цухуйж үр тариа боловсроход, зэрлэг өвс ч бас илт болов. ²⁷Гэрийн эзэн дээр боолууд нь ирж, түүнд "Эзэнтэн, та чинь талбайдаа сайн үр тариагүй бил үү? Гэтэл зэрлэг өвс хаанаас гарчихдаг билээ?" гэхэд ²⁸эзэн нь тэдэнд "Дайсан үүнийг хийжээ" гэв. Боолууд нь "Тэгвэл бид явж тэдгээрийг зулгааж овоолохыг та хүсээ юү?" гэсэнд ²⁹тэр "Хэрэггүй, та нар зэрлэг өвс зулгаах гээд буудайг хамтад нь зулгаачихаж магад. ³⁰Ургац хураатал хамтдаа ургаг. Ургац хураах цагт би хадах хүмүүстээ «Эхлээд зэрлэг өвсийг зулгааж, боогоод шатаахад бэлэн болго. Харин буудайг цуглуулж амбаарт хийцгээ» гэж хэлнэ" гэв.

³¹Есүс өөр сургаалт зүйрлэл айлдруун

—Тэнгэрийн хаанчлал бол хүн талбайдаа тарьсан гичийн үртэй төстэй. ³²Энэ нь бусад бүх үрнээс жижигхэн боловч ургахдаа ургамлаас ч илүү томорч, мод болон ургадаг тул тэнгэрийн шувууд ирж, мөчрүүд дээр нь үүрээ засдаг юм гэлээ.

³³Өөр сургаалт зүйрлэлээр

—Тэнгэрийн хаанчлал бол гурван хэмжүүр гурилыг бүхэлд нь исгэхээр нэгэн эмэгтэйн хийсэн хөрөнгөтэй төстэй гэж Есүс хэлэв.

³⁴Есүс хурсан олонд сургаалт зүйрлэлээр энэ бүхнийг айлдсан бөгөөд сургаалт зүйрлэлгүйгээр юу ч ярьсангүй. ³⁵Энэ нь эш үзүүлэгчээр хэлүүлсэн нь биелэгдэхийн тулд байсан бөгөөд ингэхдээ

«Би сургаалт зүйрлэлээр ам нээнэ.

Би дэлхийн сууриас эхлэн нууцлагдсан зүйлсийг хэлэх болно»

гэсэн байна. ³⁶Есүс хурсан олныг орхин, гэрт оров. Шавь нар нь Түүн дээр ирээд,

—Тариан талбай дахь зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийг бидэнд тайлбарлаж өгөөч гэхэд нь ³⁷Тэр

—Сайн үрийг таригч нь Хүний Хүү, ³⁸талбай нь дэлхий, сайн үрүүд нь хаанчлалын хөвгүүд, зэрлэг өвсний үрүүд нь хорон нэгний хөвгүүд, ³⁹тэдгээрийг тарьсан дайсан нь диавол, ургац нь энэ үеийн төгсгөл, тариа хадагсад нь тэнгэр элч нар юм. ⁴⁰Тиймээс зэрлэг өвсийг зулгааж шатаах адил энэ үеийн төгсгөл тийнхүү байх болно. ⁴¹Хүний Хүү тэнгэр элч нараа илгээхэд тэд хамаг бүдрүүлэх саад болоод ёс бусыг үйлдэгч хүмүүсийг Түүний хаанчлалаас гаргаж бөөгнүүлээд ⁴²галтай зууханд хаяна. Тэнд тэд уйлна, шүдээ хавирна. ⁴³Тэгэхэд зөвт хүмүүс нь Эцэгийнхээ хаанчлалд нар мэт гийх болно. Сонсох чихтэй нь сонсогтун.

⁴⁴Тэнгэрийн хаанчлал бол талбайд нуусан эрдэнэ лугаа адил юм. Түүнийг хүн олоод нууж, баярласандаа явж, өөрт байгаа бүхнээ зараад, тэрхүү талбайг худалдан авна.

⁴⁵Бас тэнгэрийн хаанчлал бол сайн сувд хайгч худалдаачинтай адил юм. ⁴⁶Их үнэтэй ширхэг сувдыг олоод, тэр явж, өөрт байсан бүхнээ зарж түүнийг авна.

⁴⁷Мөн тэнгэрийн хаанчлал бол төрөл бүрийн загас барихаар тэнгист хаясан загасны асар том тортой адил юм. ⁴⁸Тор дүүрмэгц, тэд түүнийг эрэг дээр татаж гаргаад, сайн загасыг нь саванд хийн, харин мууг нь хаяна. ⁴⁹Энэ үеийн төгсгөл ч мөн ийм байх болно. Тэнгэр элч нар ирж, зөвт хүмүүсийн дундаас муу хүмүүсийг ялгаж, ⁵⁰тэднийг галтай зууханд хаяна. Тэнд тэд уйлж, шүдээ хавирах болно.

⁵¹Та нар энэ бүхнийг ойлгов уу? гэхэд, тэд Түүнд

—Тийм ээ гэв. ⁵²Тэгтэл Есүс тэдэнд

—Иймээс тэнгэрийн хаанчлалын шавь болсон хуулийн багш бүхэн эрдэнийн сангаасаа хуучныг хийгээд шинийг гаргах өрхийн тэргүүлэгчтэй адил юм гэв.

⁵³Есүс эдгээр сургаалт зүйрлэлүүдийг ярьсныхаа дараа тэндээс явав.

⁵⁴Тэр төрөлх хотдоо ирээд, синагогт нь тэднийг сургахад тэд гайхшран

—Энэ мэргэн ухаан, эдгээр гайхамшигт хүчийг энэ хүн хаанаас авсан юм бол? ⁵⁵Энэ чинь мужааны хүү биш бил үү? Эхийг нь Мариа, дүү нарыг нь Иаков, Иосеф, Симон, Иуда гэдэг биш бил үү? ⁵⁶Охин дүү нар нь бүгд бидэнтэй хамт байгаа биз дээ? Тэгвэл энэ хүн тэр бүхнийг хаанаас авав? гэцгээв. ⁵⁷Тэд Түүнд гомдов. Харин Есүс тэдэнд

—Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, гэрийнхнээсээ өөр газар л хүндлэгддэг юм гэж айлдав. ⁵⁸Тэдний итгэлгүй байдлаас болж Тэр тэнд олон гайхамшиг үйлдсэнгүй.

[14]

¹Тэр үед захирагч Херод Есүсийн тухай сураг сонсов. ²Херод зарц нартаа

—Энэ бол баптисм хүртээгч Иохан мөн. Тэр үхлээс амилжээ. Түүний дотор гайхамшигт хүч үйлчилж байгаагийн учир нь энэ юм гэжээ. ³Учир нь Херод дүү Филиппийнхээ эхнэр Херодиагаас болж Иоханыг бариулж шоронд хорьсон байлаа. ⁴Яагаад гэвэл Иохан Херодод

—Та хууль бусаар Херодиаг авсан байна гэж хэлсэн ажээ. ⁵Хэдийгээр тэр Иоханыг алахыг хүссэн боловч хурсан олноос айж байлаа. Учир нь тэд Иоханыг эш үзүүлэгч гэж үздэг байв. ⁶Харин Херодын төрсөн өдрөөр Херодиагийн охин олны өмнө бүжиглэж, Херодод таалагдав. ⁷Тиймээс Херод түүнд юу гуйсныг чинь өгье гэж андгайлан амлав. ⁸Охин эхийнхээ ятгаснаар

—Энэ царан дээр баптисм хүртээгч Иоханы толгойг тавиад надад өгөөч гэж гуйжээ. ⁹Хэдийгээр хаан харууссан боловч андгайлсан бөгөөд хамт байсан зочдоос зовж өгтүгэй хэмээн тушаав. ¹⁰Ингээд тэр хүн илгээж Иоханыг шоронд цаазлууулжээ. ¹¹Толгойг нь царан дээр авчирж охинд өгсөнд тэр эхдээ аваачиж өгөв. ¹²Иоханы шавь нар ирээд биеийг нь аван оршуулаад, явж Есүст мэдэгдэв.

¹³Есүс үүнийг сонсоод тэндээс гарч завиар зэлүүд газар уруу ганцаараа явжээ. Хурсан олон сонсоод, хотоос гарч Түүнийг явганаар дагалаа. ¹⁴Эрэг дээр гарахдаа Есүс асар олон хүн байхыг хараад тэднийг ихэд өрөвдөн, өвчтөнүүдийг нь эдгээв. ¹⁵Орой болох үед шавь нар нь Түүн дээр ирж,

—Энэ газар зэлүүд, мөн цаг хэдийнээ талийжээ. Хурсан олныг тараан явуулаач! Тэгвэл тэд гацаанууд уруу явж, өөрсөддөө хоол хүнс худалдаж авах болно шүү дээ гэцгээв. ¹⁶Харин Есүс тэдэнд

—Тэд явах хэрэггүй. Та нар тэдэнд идэх юм өг гэхэд, ¹⁷тэд Түүнд

—Бидэнд ердөө л таван талх, хоёрхон загас байна гэсэнд

— ¹⁸Нааш нь аваад ир гэж Тэр хэлэв. ¹⁹Есүс хурсан олонд зүлэг ногоон дээр суухыг тушаагаад таван талх, хоёр загасыг авч, тэнгэр өөд ширтэж, хүнсийг ерөөгөөд талхаа хувааж шавь нартаа өгөв. Шавь нар нь хурсан олонд өгөхөд ²⁰тэд бүгд идэж, цаджээ. Тэгээд тэд үлдэгдэл өвдөл цөвдлийг нь цуглуулахад арван хоёр сагс дүүрэв. ²¹Тэнд эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна таван мянга орчим эрчүүд байж идсэн ажээ.

²²Есүс хурсан олныг явуулах зуураа даруй шавь нарыгаа завинд нь албадан суулгаж, Өөрийнхөө түрүүнд тэднийг нөгөө эрэг уруу явуулав.

²³Хурсан олныг явуулсны дараа Тэр ганцаараа залбирахаар ууланд гарчээ. Орой болоход тэр тэнд ганцаараа байв. ²⁴Харин завь хэдийнээ эргээс олон бээр холдсон байв. Салхи өөдөөс нь салхилж байсан тул давалгаанд түрэгдэн байлаа. ²⁵Шөнийн дөрөвдүгээр манааны үед Тэр нуурын дээр алхан тэднийг зүглэн ирж явав. ²⁶Нууран дээр алхаж яваа Түүнийг хараад шавь нар нь сандарч,

—Энэ чинь хий үзэгдэл байна гээд айснаасаа болж хашхиралдав.

²⁷Харин тэр даруй Есүс тэдэнд

—Зоригтой бай. Би байна. Бүү ай гэжээ. ²⁸Петр Түүнд

—Эзэн, хэрэв Та мөн юм бол, усан дээр алхаж Өөр уруу тань ирэхийг надад тушаагаач гэхэд ²⁹Тэр

—Ир гэлээ. Петр завинаасаа гарч, усан дээр алхлан Есүс уруу явав.

³⁰Харин Петр салхи хараад, айн, живж эхлэв. Тэгээд

—Эзэн, намайг авраач гэж орилоход нь, ³¹Есүс тэр даруй гараа сунган, түүнийг зууран,

—Бага итгэлт минь, чи юунд эргэлзэв? гэжээ. ³²Тэр хоёрыг завин дээр гарахад, салхи зогсжээ. ³³Завин дээр байсан хүмүүс Түүнд мөргөж

—Та бол үнэхээр Бурханы Хүү мөн гэцгээв.

³⁴Тэгээд тэд нуурыг гаталж, Геннесаретын нутагт хүрчээ. ³⁵Тэр нутгийн хүмүүс Түүнийг таниад, хавь орчмынхоо бүх газарт хүн илгээж өвчтэй хүн бүрийг Түүн уруу авчирлаа. ³⁶Тэд зөвхөн дээлийнх нь хормойд гар хүрэхийг л гуйж байв. Тэгээд хүрсэн бүхэн эдгэж байлаа.

[15]

¹Тэгтэл Иерусалимаас хэсэг фарисайчууд болоод хуулийн багш нар Есүс дээр ирж,

— ²Таны шавь нар юунд ахмадын ёс заншлыг зөрчинө вэ? Тэд талх идэхдээ гараа угаахгүй юм гэцгээхэд ³Тэр хариуд нь тэдэнд

—Яагаад та нар өөрсдөө ёс заншлынхаа төлөө Бурханы тушаалуудыг зөрчинө вэ? ⁴Бурхан "Эцэг, эхээ хүндэл", "Эцэг, эхээ муугаар хэлэгчийг ал" гэж айлдсан. ⁵Гэтэл та нар "Хэрэв хэн эцэг, эсвэл эхдээ «Та нарт тусалж магадгүй байсан өөрийн ямар ч зүйлээ Бурханд өргөсөн» гэж хэлнэ, ⁶тэр нь эцгээ, эсвэл эхээ хүндлэх хэрэггүй" гэдэг. Та нар ийнхүү ёс заншлынхаа төлөө Бурханы үгийг хүчингүй болголоо. ⁷Зальхай хүмүүс ээ, Исаиа та нарын тухай зөв эш үзүүлсэн юм. Ингэхдээ

⁸"Энэ ард түмэн Намайг амаараа хүндэлдэг.

Гэвч тэдний зүрх Надаас алс хол байдаг.

⁹Тэд хүнээс гарсан тушаал зааврыг сургаж,
Надад дэмий хоосноор мөргөж байна"

гэсэн гэв. ¹⁰Хурсан олныг Тэрээр Өөр уруугаа дуудсаны дараа тэдэнд

—Сонс, ухаар. ¹¹Аманд орсон юм хүнийг бузарладаггүй, харин амнаас гарч буй нь хүнийг бузарладаг юм гэхэд ¹²шавь нар нь ойртож очоод Түүнд

—Энэ үгсийг тань сонсоод фарисайчууд гомдсоныг Та мэдэв үү? гэжээ.

¹³Харин Есүс хариуд нь

—Тэнгэрлэг Эцэгийн минь тариагүй алив ургамал үндсээрээ сугалагдана.

¹⁴Тэднийг орхи. Тэд бол сохруудыг удирддаг сохрууд юм. Хэрэв сохор нь сохроо удирдвал, тэд хоёул нүхэнд унах болно гэхэд, ¹⁵Петр Түүнд

—Энэ сургаалт зүйрлэлийг бидэнд тайлбарлаж өгөөч гэсэнд, ¹⁶Тэр

—Та нар мөн л ойлгохгүй хэвээр байна уу? ¹⁷Ам уруу орох алив зүйл гэдсэнд ороод арилдгийг ойлгохгүй байна гэж үү? ¹⁸Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг. ¹⁹Зүрхнээс хорон муу

бодол, аллага, завхайрал, садар самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь гардаг. ²⁰Эдгээр нь хүнийг бузарладаг. Харин гараа угаалгүй идэх нь хүнийг бузарладаггүй гэжээ.

²¹Есүс тэндээс явж, Тир болон Сидоны нутагт ирэв. ²²Нэгэн Канаан эмэгтэй тэр мужаас ирж,

—Давидын Хүү Эзэн, намайг өршөөгөөч. Охиныг маань чөтгөр хэрцгийгээр эзэмдэж байна гэж орилов. ²³Харин Есүс түүнд нэг ч үг хэлсэнгүй. Тэгтэл шавь нар нь ирээд, Түүнээс

—Түүнийг явуулаач. Тэр эмэгтэй бидний араас хашхирсаар байна шүү дээ гэж гуйв. ²⁴Гэтэл Есүс

—Би Израилийн гэрийн зөвхөн алдагдсан хонинууд уруу илгээгдсэн юм гэсэн ²⁵боловч өнөөх эмэгтэй дөхөж ирээд, Түүний өмнө мөргөж,

—Эзэн, надад туслаач гэхэд, ²⁶Есүс

—Хүүхдүүдийн талхыг авч, ноходод хаяж өгөх нь сайн хэрэг бишээ гэв. ²⁷Харин тэр

—Тийм ээ, Эзэн. Гэвч ноход ч эздийнхээ ширээнээс унасан үйрмэгээр хооллодог шүү дээ гэсэнд, ²⁸Есүс

—Эмэгтэй ээ, итгэл чинь агуу юм. Чиний хүссэнээр бүтэг гэхэд, охин нь тэр дороо эдгэрчээ.

²⁹Тэгээд Есүс тэндээс явж, Галилын нуурын хавьд ирээд, ууланд гарч тэндээ сууж байлаа. ³⁰Маш олон хүн Түүн дээр доголон, тахир дутуу, сохор, дүлий болон олон хүнийг авч ирээд хөл дор нь тавилаа. Тэр тэднийг эдгээв. ³¹Хэлгүйчүүдийн ярихыг, тахир дутуу хүмүүсийн эрүүл болохыг, хазгар доголонгуудын явахыг, сохруудын харахыг хурсан олон үзээд гайхан, Израилийн Бурханыг алдаршуулав.

³²Есүс шавь нараа Өөр дээрээ дуудаад, тэдэнд

—Би энэ хурсан олныг өрөвдөж байна. Тэд надтай хамт гурван өдрийн турш байж, ямар ч идэх юмгүй болжээ. Би тэднийг өлөн зэлмүүн явуулмааргүй байна. Тэд замдаа сульдах вий гэхэд нь, ³³шавь нар нь Түүнд

—Бид энэ зэлүүд газар ийм олон хүмүүсийг цатгах талхыг хаанаас олох билээ? гэсэнд, ³⁴Есүс

—Та нарт хэдэн талх байна? гэв. Тэд

—Долоо. Бас хэдэн жижиг загас байна гэлээ. ³⁵Тэр хурсан олонд газар суухыг тушаагаад, ³⁶долоон талх, мөн загасыг авч талархал өргөн хуваагаад, шавь нартаа өгч эхэлсэнд тэд хүмүүст тараан өгөв. ³⁷Бүгд идэж цадаад үлдсэн хэлтэрхийнүүдийг цуглуулахад долоон том сагс дүүрсэн байлаа. ³⁸Эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна тэнд байсан дөрвөн мянган эрчүүд идсэн юм. ³⁹Тэгээд хурсан олныг явуулаад, Тэр завинд сууж, Магаданы нутагт очив.

[16]

¹Фарисай болон садикайчууд ирээд Түүнийг сорьж тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг гуйв. ²Есүс тэдэнд хариуд нь

—Орой болохоор та нар "Тэнгэр улаарч байна. Цэлмэг болох нь" гэдэг. ³Өглөө нь "Тэнгэр улаан, бүрхэг байна, өнөөдөр шуургатай байх нь" гэж ярьдаг. Та нар тэнгэрийн байдлыг ялган мэдэж чаддаг хэрнээ цаг үеийн тэмдгүүдийг ялгаж эс чадна уу? ⁴Бузар болон завхай үеийнхэн тэмдгийг эрэлхийлдэг. Ионагийн тэмдгээс гадна өөр тэмдэг өгөгдөхгүй гэж хэлээд Тэр тэднийг орхин явлаа.

⁵Шавь нар нь нөгөө талд ирэхдээ талх авчрахаа мартсан ажээ. ⁶Есүс тэдэнд

—Фарисай болон садикайчуудын хөрөнгөнөөс сэрэмжил, болгоомжил гэхэд, ⁷тэд өөр хоорондоо

—Энэ нь бид талх аваагүйгээс болсон хэрэг гэгцгээв. ⁸Харин Есүс үүнийг мэдээд

—Итгэл багатай хүмүүс ээ, та нар чинь юунд хоорондоо талх байхгүйгээ ярилцана вэ? ⁹Одоо хүртэл та нар ойлгож ч, санаж ч чадахгүй байгаа юм уу? Таван талхаар таван мянган хүнийг хооллоход хичнээн сагс цуглуулсан билээ? ¹⁰Эсвэл долоон талхыг дөрвөн мянган хүнд өгч, хичнээн том сагс цуглуулснаа ч санахгүй байна уу? ¹¹Би та нарт талхны тухай яриагүйг яагаад ойлгодоггүй юм бэ? Харин фарисай болоод садикайчуудын хөрөнгөнөөс болгоомжил гэв. ¹²Тэгэхэд л тэд Есүс талхны хөрөнгөнөөс биш, харин фарисай болон садикайчуудын сургаалаас болгоомжил гэж айлдсаныг ухаарав.

¹³Есүс Цезарь Филиппийн нутагт очих үедээ шавь нараасаа

—Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? гэж асуув. ¹⁴Тэгэхэд нь тэд

—Зарим нь баптисм хүртээгч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл эш үзүүлэгчдийн нэг гэж ярьдаг гэхэд, ¹⁵Тэр

—Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ? гэсэнд, ¹⁶Симон Петр

—Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв. ¹⁷Есүс түүнд хариуд нь

—Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм. ¹⁸Би мөн чамд хэлье. Чи бол Петр. Энэ хадан дээр Би Өөрийн чуулганыг босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. ¹⁹Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно гэлээ. ²⁰Тэгээд Тэр Өөрийг нь Христ мөн гэдгийг хэнд ч хэлэх ёсгүйг шавь нартаа анхааруулав.

²¹Тэр цагаас эхлэн Есүс Христ шавь нартаа Өөрийн Иерусалим уруу явах, ахлагчид, ахлах тахилч нар болон хуулийн багш нараас их зовлон амсах, алуулах, гурав дахь хоног дээрээ амилах ёстойгоо илэрхийлж эхлэв.

²²Петр Түүнийг татаж

—Эзэн минь, Таныг Бурхан өршөөг. Ийм юм Танд хэзээ ч тохиолдохгүй гэж зэмлэж эхэлсэнд, ²³Тэр эргэж Петрт

—Миний араас зайл, Сатан аа! Чи Надад бүдрэх чулуу болж байна. Учир нь чи Бурханы юмыг бус, харин хүнийхийг л боддог гэлээ. ²⁴Тэгээд Есүс шавь нартаа

—Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгэг. Загалмайгаа үүрч, Намайг дагаг. ²⁵Учир нь хэн өөрийнхөө амийг аврахыг хүснэ, тэр хүн түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ олно. ²⁶Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх билээ? ²⁷Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө. ²⁸Үнэнээр Би та нарт хэлье. Энд зогсож байгаа хүмүүсээс зарим нь Хүний Хүүг хаанчлалынхаа дотор ирэхийг харах хүртэл үхлийг үл амсана гэж айлдав.

[17]

¹Зургаан өдрийн дараа Есүс Петр, Иаков болон түүний дүү Иохан нарыг дагуулан өндөр ууланд гарчээ. ²Тэр тэдний өмнө хувирч өөрчлөгдөв. Түүний нүүр нар мэт гэрэлтэж, хувцас нь гэрэл мэт цагаан болсон байлаа. ³Харагтун. Мосе, Елиа нар Түүнтэй ярилцаж байгаа нь тэдэнд үзэгдэв. ⁴Петр Есүст

—Эзэн, энд байгаа маань бидэнд сайн боллоо. Хэрэв Таныг хүсвэл энд гурван цацар барьж өгье. Нэгийг нь Танд, нэгийг нь Мосед, нэгийг нь Елиад зориулъя гэв. ⁵Тийн ярьж байтал харагтун, гэрэлт үүл тэднийг бүрхэн авахад үүлнээс

—Энэ бол Миний хайрт Хүү мөн. Түүнд Миний таалал оршдог. Түүнийг сонсогтун гэх дуу гарав. ⁶Шавь нар үүнийг сонсоод нүүрээрээ унаж, ихэд айв. ⁷Есүс ирж тэдэнд гар хүрч

—Бос, бүү ай гэлээ. ⁸Тэд толгойгоо өргөн харахад, Есүсээс өөр хэнийг ч олж харсангүй.

⁹Тэд уулаас бууж явахад Есүс тэдэнд

—Хүний Хүүг үхэгсдээс амилтал энэ үзэгдлийг хэнд ч бүү хэл гэж тушаав. ¹⁰Шавь нар нь Түүнээс

—Тэгвэл яагаад хуулийн багш нар Елиаг эхэнд ирэх ёстой гэдэг юм бэ? гэж асуухад, ¹¹Тэр хариуд нь

—Елиа үнэхээр ирж, бүгдийг сэргээх болно. ¹²Харин Би та нарт хэлье. Елиа хэдийнээ ирсэн. Тэд түүнийг таниагүй бөгөөд хүссэн бүхнээ түүнд хийсэн. Түүнчлэн Хүний Хүү тэдний гарт зовох болно гэж айлдав. ¹³Тэгэхэд л баптисм хүртээгч Иоханы тухай Тэр ярьсныг шавь нар нь ойлгожээ.

¹⁴Тэднийг хурсан олон уруу ирэх үед нэгэн хүн Түүнийг тосон очоод өмнө нь сөхрөн,

— ¹⁵Эзэн, миний хүүг өршөөгөөч. Хүү маань солиотой. Тэр их өвчтэй байна. Гал усанд байнга унаж ойчдог юм. ¹⁶Би түүнийг Таны шавь нар дээр авчирсанд тэд эдгээж чадсангүй гэв. ¹⁷Есүс

—Итгэлгүй, тэрслүү үеийнхэн. Хэдий болтол би та нартай байх юм бэ? Хэдий болтол та нарыг тэсвэрлэх юм бэ? Түүнийг Над уруу аваад ир гээд,

¹⁸Есүс түүнийг зэмлэсэнд, чөтгөр түүнээс гарч, хүү тэр мөчөөс эхлэн эдгэрэв.

¹⁹Тэгтэл шавь нар нь Есүс уруу хувьчлан ирж,

—Бид яагаад түүнийг хөөн гаргаж чадсангүй вэ? гэж асуусанд, ²⁰Есүс

—Итгэл чинь бага учраас. Үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв гичийн үр төдийхөн итгэл та нарт байвал, энэ ууланд "Эндээс тийшээ нүү" гэж хэлбэл тэр нь нүүнэ. Та нарт боломжгүй юм гэж байхгүй болно. ²¹[Гэвч энэ төрлийн чөтгөр нь мацаг барилт, залбирлаар л гардаг хэмээн айлдав.]

²²Тэднийг Галилд цугтаа байхад нь Есүс тэдэнд

—Хүний Хүү хүмүүсийн гарт тушаагдах болно. ²³Тэд Түүнийг алах бөгөөд Тэр гурав дахь өдрөө амилна гэхэд тэд ихэд гашуудлаа.

²⁴Тэднийг Капернаумд ирэхэд нь хоёр драхмын татвар хураагч нар Петр дээр ирээд

—Танай багш чинь хоёр драхмын татвараа төлдөггүй юм уу? гэсэнд, ²⁵тэр

—Төлдөг гэв. Тэгээд Петрийг гэрт ороход Есүс түрүүлэн түүнд

—Симон оо, чи юу гэж боддог вэ? Газрын хаад хэнээс гааль, эсвэл албан татварыг авдаг вэ? Өөрсдийн хөвгүүдээс үү, эсвэл гадны хүмүүсээс үү? гэхэд ²⁶тэр

—Гадны хүмүүсээс гэж хариулахад Есүс

—Тэгвэл хөвгүүд нь чөлөөлөгдсөн байх нь. ²⁷Гэвч бид тэднийг гомдоохгүйн тулд чи тэнгис уруу явж, дэгээ хая. Эхний барьсан загасны амыг нээж үзвэл дөрвөн драхмын нэг зоосыг олно. Түүнийг авч Миний өмнөөс болон өөрийнхөө өмнөөс тэдэнд аваачиж өг гэж айлджээ.

[18]

¹Тэр үед шавь нар нь Есүс уруу ирж,

—Тэнгэрийн хаанчлалд хэн хамгийн агуу нь байх вэ? гэж асуужээ. ²Тэр нэгэн хүүхдийг Өөр уруугаа дуудаад, тэдний дунд зогсоож айлдсан нь

— ³Үнэнээр Би та нарт хэлье. Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй. ⁴Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь

болно. ⁵Миний нэрээр ийм хүүхдийг хүлээн авсан хэн боловч Намайг хүлээн авсан хэрэг. ⁶Харин хэн Надад итгэгч эдгээр багачуудаас нэгийг нь бүдрүүлнэ, түүний хувьд хүзүүндээ тээрмийн хүнд чулуу зүүгээд тэнгисийн гүнд живсэн нь дээр.

⁷Бүдрүүлэх сааднуудынхаа улмаас ертөнц золгүй еэ! Юу гэвэл бүдрүүлэх саад ирэх нь зайлшгүй бөгөөд харин бүдрүүллийг гүйцэлдүүлэгч тэр хүн золгүй еэ! ⁸Хэрэв гар чинь, эсвэл хөл чинь чамайг бүдрүүлбэл, тас цавчин хая. Хоёр гартайгаа, эсвэл хоёр хөлтэйгөө мөнхийн галд хаягдсанаас гаргүй, эсвэл хөлгүйгээр аминд орох нь чамд дээр. ⁹Хэрэв нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж хая. Хоёр нүдтэйгээр галт тамд хаягдсанаас нэг нүдтэй аминд орох нь чамд дээр. ¹⁰Та нар эдгээр багачуудын нэгийг нь ч бүү басамжил. Би та нарт хэлье. Тэнгэр дэх тэдний тэнгэр элч нар нь тэнгэрт байгаа Миний Эцэгийн нүүрийг байнга хардаг юм. ¹¹[Учир нь Хүний Хүү алдагдсаныг аврахаар ирсэн юм] ¹²Та нар юу гэж бодож байна вэ? Хэрэв хэн нэгэн хүн зуун хоньтой байтал, тэднээс нэг нь төөрвөл, тэр ерэн есөн хонио ууланд орхичихоод төөрсөн нэгийг хайхаар явахгүй гэж үү? ¹³Үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв тэр олчихвол, төөрөөгүй ерэн есөн хониноосоо илүүгээр түүнд баярлах болно. ¹⁴Тиймд эдгээр багачуудаас хэн нэг нь эрсдэх нь тэнгэрт байгаа Эцэгийн тань хүсэл биш юм.

¹⁵Хэрэв ах дүү чинь нүгэл үйлдвэл, явж түүнтэй ганцаарчлан уулзан зэмлэ. Хэрэв тэр чамайг сонсвол, чи ах дүүгээ олж авсан хэрэг. ¹⁶Харин тэр үл сонсвол, өөртэйгөө хамт нэг юмуу хоёр ах дүүгээ дагуул. Тэгвэл хоёр буюу гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдох болно. ¹⁷Хэрэв тэр тэднийг сонсохоос татгалзвал, чуулганд хэл. Хэрэв чуулганыг хүртэл сонсохоос татгалзвал, тэр чиний хувьд харь үндэстэн болоод татвар хураагч мэт байг. ¹⁸Үнэнээр Би та нарт хэлье. Та нар газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдох бөгөөд газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт мөн тайлагдах болно. ¹⁹Би та нарт дахин хэлье. Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний Эцэг үүнийг нь тэдний төлөө биелүүлэх болно. ²⁰Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав.

²¹Дараа нь Петр ирж Түүнд

—Эзэн, ах дүү маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? Долоон удаа юу? гэхэд нь ²²Есүс айлдсан нь

—Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин дал дахин долоон удаа гэж хэлье. ²³Иймээс тэнгэрийн хаанчлалыг боолуудтайгаа тооцоо хийхийг хүссэн нэгэн хаантай зүйрлэж болно. ²⁴Тэр тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй нэгийг нь түүн уруу аваачив. ²⁵Харин түүнд өрөө төлөх юм байхгүй тул эзэн нь түүнийг эхнэр, хүүхдүүдийнх нь хамт хамаг юмтай нь худалдаад өрийг нь барагдуулахыг тушаажээ. ²⁶Боол нь сөхрөн унаж, сунан мөргөөд түүнээс "Намайг тэвчин хүлцэнэ үү. Би танд бүгдийг буцааж төлнө" гэж гуйхад ²⁷тэрхүү боолын эзэн нь түүнийг ихэд өрөвдөөд суллаж, өрийг нь хэлтрүүлжээ. ²⁸Харин өнөөх боол гадагш гараад, өөрт нь зуун денарын өртэй байсан өөрийнхөө анд нөхөр болох нэгэн боолыг олж хараад, барин авч хоолойг нь шахаж, "Өрөө төл" гэв. ²⁹Харин анд нөхөр нь болох тэр боол сөхрөн унаж, түүнээс гуйн "Намайг тэвчин хүлцээч. Чамд буцааж төлнө" гэж хэлжээ. ³⁰Тэр үүнийг хүсээгүй учраас явж, түүнийг өр ширээ буцааж төлтөл нь шоронд хориулав. ³¹Түүний бусад найз боолууд нь болсон явдлыг хараад ихэд гуниж, эзэн дээрээ очиж болсон бүгдийг нь мэдэгджээ. ³²Тэгтэл эзэн нь нөгөөх боолыг дуудаад, түүнд "Бузар муу боол оо, чи надаас гуйсан тул би бүх өрийг чинь хэлтрүүлсэн. ³³Би чамайг өршөөсний адил чи бас анд нөхөр чинь болох тэр боолыг өршөөх ёстой байсан бус уу?" гээд, ³⁴ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг буцаан төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажээ. ³⁵Түүнчлэн хэрэв та нарын нэг бүр чинь ах дүүгээ зүрх сэтгэлээсээ уучлахгүй бол Миний тэнгэрлэг Эцэг ч та нарт мөн тэгж хандах болно гэлээ.

[19]

¹Есүс эдгээр үгээ айлдсаныхаа дараа, Галилаас явж, Иорданы тэртээх Иудейн нутагт ирэв. ²Үй олон хүмүүс Түүнийг дагахад тэнд Тэр тэднийг эдгээжээ.

³Түүн дээр хэсэг фарисайчууд ирээд, Түүнийг сорьж,

—Ямар нэг шалтгаанаар эхнэрээсээ салах нь хуулийн дагуу мөн үү? гэж асуухад ⁴Тэр хариуд нь

—Бүтээгч анхнаасаа тэднийг эр, эмээр нь бүтээснийг та нар уншаагүй гэж үү? гээд

—⁵Тиймээс эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёулаа нэг бие махбод болдог. ⁶Тиймд тэд цаашид хоёр бус, харин нэг бие махбод юм.

Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг гэж айлдав.

⁷Гэтэл тэд Түүнд

—Тэгвэл Мосе яагаад эхнэртээ салалтыг гэрчилсэн бичиг өгөөд, түүнийг явуулахыг тушаасан юм бэ? гэхэд, ⁸Тэр тэдэнд

—Яагаад гэвэл та нарын зүрх хатуу тул Мосе эхнэрээсээ салахыг та нарт зөвшөөрсөн юм. Гэвч анхнаасаа ийм байгаагүй. ⁹Би та нарт хэлье. Хэн садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салж, өөр эмэгтэйтэй гэрлэнэ, тэр нь завхайрсан болно гэв. ¹⁰Шавь нар нь Түүнд

—Хэрэв нөхөр эхнэрийн харьцаа ийм байвал, гэрлэхгүй байсан нь дээр юм гэхэд ¹¹харин Есүс тэдэнд

—Ингэж хэлэхийг бүх хүн хүлээн зөвшөөрч чадахгүй, харин энэ нь өгөгдсөн хүмүүс л чадна. ¹²Учир нь эхийнхээ хэвлийгээс төрөхдөө тайган төрсөн хүн байдаг. Хүмүүсийн тайган болгосон тайган хүмүүс ч байдаг. Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм. Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг гэж айлдав.

¹³Есүсийн гарыг нь тавиулж, тэдний төлөө залбируулахын тулд хүмүүс Түүн дээр хүүхдүүдийг авчирсанд шавь нар тэднийг зэмлэжээ. ¹⁴Харин Есүс

—Хүүхдүүдийг зөвшөөр, Над уруу ирэхийг бүү болиул. Учир нь тэнгэрийн хаанчлал бол эдний адил хүмүүсийнх юм гээд, ¹⁵тэдний дээр гараа тавьсны дараа тэндээс явав.

¹⁶Үзэгтүн, нэгэн хүн Түүн уруу ирээд,

—Багш аа, мөнх амийг олохын тул би ямар сайн юм хийх ёстой вэ? гэж асуухад, ¹⁷Есүс

—Чи Надаас юунд сайн нь юу болох тухай асууна вэ? Сайн нь зөвхөн Ганц байдаг. Хэрэв чи амьтай болохыг хүсэж байгаа бол тушаалуудыг сахь гэв. ¹⁸Тэр Түүнд

—Алийг нь? гэхэд Есүс

—Чи хүн бүү ал. Чи бүү завхайр. Чи бүү хулгайл. Чи бүү худал гэрчил. ¹⁹Эцэг эхээ хүндэл. Чи хөршөө өөрийн адил хайрла гэжээ. ²⁰Өнөөх залуу эр Түүнд

—Энэ бүхнийг би сахьсан. Надад өөр юу дутагдаж байна вэ? гэхэд, ²¹Есүс

—Хэрэв чи төгс байхыг хүсэж байвал, явж эд хөрөнгөө зарж ядууст өг. Тэгвэл чи тэнгэрт эрдэнэстэй болно. Тэгээд ирж, Намайг дага гэлээ. ²²Тэр залуу энэ зааврыг сонсоод, гунигтайгаар холдон явлаа. Учир нь тэр маш их хөрөнгөтэй нэгэн байжээ.

²³Есүс шавь нартаа

—Үнэнээр Би та нарт хэлье. Баян хүн тэнгэрийн хаанчлалд орох нь нэн бэрх аж. ²⁴Би та нарт дахин хэлье. Баян хүн Бурханы хаанчлалд орохоос тэмээ зүүний сүвэгчээр нэвтрэх нь илүү хялбар гэв. ²⁵Шавь нар нь үүнийг сонсоод ихэд гайхан

—Тэгвэл хэн аврагдаж чадах вэ? гэцгээхэд ²⁶Есүс тэднийг хараад,

—Энэ нь хүмүүст боломжгүй, харин Бурханд бүх юм боломжтой гэж айлдав. ²⁷Тэгтэл Петр Түүнд

—Хараач, бид бүх зүйлсийг орхиод Таныг дагасан. Тэгвэл бидэнд юу байх вэ? гэхэд ²⁸Есүс айлдсан нь

—Үнэнээр Би та нарт хэлье. Хүний Хүү Өөрийн сүр жавхлант сэнтийдээ залрах үед Намайг дагасан та нар ч мөн арван хоёр Израилийн арван хоёр овгийг шүүж, арван хоёр сэнтий дээр залрах болно. ²⁹Миний нэрийн төлөө өөрийн гэр орноо, ах дүүсээ, эгч дүүсээ, эсвэл эцэг эхээ, хүүхдүүдээ, эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг өвлөх болно. ³⁰Харин эхэнд байгаа олон хүн сүүлчийнх, сүүлчийнх нь эхнийх байх болно.

[20]

¹Тэнгэрийн хаанчлал нь усан үзмийн талбайдаа ажиллуулах хүмүүсийг хөлслөхөөр өглөө эрт гарсан газрын эзэнтэй төстэй юм. ²Тэр тэдэнд өдрийн нэг денар өгөхөөр ажилчидтай тохиролцон, тэднийг усан үзмийн тариалан уруугаа илгээв. ³Гуравдугаар цагийн орчим тэр гадагш гарч, зах дээр ажилгүй зогсож буй өөр хүмүүсийг хараад, ⁴тэдэнд "Та нар бас усан үзмийн тариалан уруу яв. Би та нарт шударгаар төлнө" гэсэнд тэд явжээ. ⁵Зургадугаар болон есдүгээр цагийн орчим тэр дахин гадагш гарч, түүнчлэн хүмүүсийг явуулав. ⁶Арван нэгдүгээр цагийн орчим тэр гадагш гарч, зогсож буй өөр хүмүүсийг олж, тэднээс "Та нар чинь юунд энд бүхэл өдрийн турш ажилгүй дэмий зогсоно вэ?" гэж асуусанд ⁷тэд "Биднийг хэн ч хөлсөлсөнгүй" гэв. Тэгэхэд нь тэр "Та нар бас усан үзмийн тариалан уруу

яв" гэлээ. ⁸Орой болоход усан үзмийн тариалангийн эзэн даамалдаа "Ажилчдыг дуудаж, эцсийн бүлгээс эхнийхийг хүртэл хөлсийг нь төл" гэжээ. ⁹Арван нэгдүгээр цагийн үед хөлслөгдсөн нь бүгд нэг нэг денараа хүртэв. ¹⁰Эхэнд ирсэн хүмүүс өөрсдийгөө илүү ихийг авна байх хэмээн бодсон авч мөн адил нэг нэг денар авчээ. ¹¹Тэд хөлсөө аваад газрын эзэнд дургүйцэн, гомдоллож, ¹²"Энэ сүүлчийн хүмүүс ердөө нэг л цаг ажилласан шүү дээ. Ажлын хүндийг үүрч, өдрийн халуунд ажилласан биднийг тэдэнтэй адил үнэллээ" гэжээ. ¹³Гэвч эзэн тэдний нэгэнд "Анд минь, би чамд ямар ч буруу юм хийгээгүй. Чи нэг денараар ажиллана гэж надтай тохирсон биш үү? ¹⁴Өөрийнхөө хөлсийг аваад, замаараа явж үз. Харин би энэ сүүлчийн хүнд чамд өгсөнтэй адил хөлсийг өгөхийг хүсэж байна. ¹⁵Би өөрийнхөө юмыг хүссэнээрээ зарах нь миний хувьд ёс бус юм гэж үү? Эсвэл өгөөмөр зангаас минь болж нүдэнд чинь атаархал хурав уу?" гэжээ. ¹⁶Тиймээс сүүлчийнх нь эхнийх болж, эхнийх нь сүүлчийнх байх болно гэж айлдав.

¹⁷Есүс Иерусалим уруу өгсөн явах гэж байхдаа арван хоёр шавиа дэргэдээ аваад замдаа тэдэнд

— ¹⁸Харагтун, бид Иерусалимыг зорин явж байна. Хүний Хүү ахлах тахилч нар, хуулийн багш нарын гарт тушаагдах бөгөөд тэд Түүнийг алахаар яллаж, ¹⁹харь үндэстэнд тушааж, тэд нараар доромжлуулж, ташуурдуулж, цовдлуулна. Гурав дахь өдрөө Тэр амилах болно гэлээ.

²⁰Тэгтэл Зебедеен хөвгүүдийн эх хөвгүүдийнхээ хамт Түүн дээр ирээд өмнө нь мөргөж, Түүнд хүсэлт тавив. ²¹Есүс түүнд

—Та юу хүсээ вэ? гэхэд тэр

—Та Өөрийнхөө хаанчлалд хоёр хүүгийн минь нэгийг нь Өөрийнхөө баруун талд, нөгөөг нь зүүн талдаа суу гэж тушаагаач гэв. ²²Харин Есүс

—Та нар юу гуйж байгаагаа мэдэхгүй байна. Миний уух аяганаас та нар ууж чадах уу? гэсэнд тэд

—Чадна гэгцгээв. ²³Тэр тэдэнд

—Та нар Миний аяганаас ууна. Харин Миний баруун, зүүн талд суухыг чинь Би шийдэхгүй. Харин энэ бол Миний Эцэгийн бэлтгэсэн хүмүүсийнх юм гэж хэлжээ. ²⁴Үүнийг сонсоод арав нь ах дүү хоёрт зэвүүцэв. ²⁵Харин Есүс тэднийг Өөртөө дуудаад,

—Харь үндэстний захирагчид тэднийг ноёрхдог бөгөөд ихэс дээдэс нь тэднийг захирах эрх мэдэл эдэлдгийг та нар мэднэ. ²⁶Та нар тэгж болохгүй. Харин та нарын дунд хэн чинь агуу нэгэн болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. ²⁷Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. ²⁸Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв.

²⁹Тэднийг Иерихогоос гарч явахад асар олон хүмүүс Түүнийг дагаж байлаа. ³⁰Үзэгтүн. Замын хажууд суугаа хоёр сохор Есүсийг дэргэдүүр нь өнгөрөхийг сонсоод,

—Давидын Хүү, Эзэн минь ээ, биднийгээ өршөөгөөч гэж хашхиралдав. ³¹Олон түмэн тэднийг дуугүй бай хэмээн зандарсан боловч тэд улам чангаар

—Давидын Хүү, Эзэн минь ээ, биднийгээ өршөөгөөч гэж хашхирав. ³²Есүс зогсож тэднийг дуудаад,

—Өөрсдийнхөө төлөө Надаар юу хийлгэхийг хүснэ вэ? гэхэд, ³³тэд

—Эзэн, нүд маань нээгдэхийг бид хүсэж байна гэв. ³⁴Есүс тэднийг ихэд өрөвдөж, нүдэнд нь гар хүрэхэд тэр даруй тэд хараа орж Түүнийг дагалаа.

[21]

¹Тэд Иерусалимд ойртон ирж, Чидун уулын бэл дэх Бетфагт очоод, Есүс хоёр шавиа илгээхдээ, ²тэдэнд

—Эсрэг талд чинь байгаа тосгон уруу яв. Тэр даруй та нар нэгэн уяатай илжгийг дудрантайгаа байгааг олно. Тэднийг тайлаад, Над уруу авчир. ³Хэрэв хэн нэгэн хүн та нарт юм хэлбэл, "Эд Эзэнд хэрэгтэй" гэж хэлээрэй. Тэгвэл тэр хүн тэднийг даруй явуулна гэж айлджээ. ⁴Энэ нь эш үзүүлэгчээр хэлүүлсэн нь биелэгдэхийн тул болой. Юу гэвэл

⁵«Сионы охинд хэл.

"Харагтун, чиний Хаан чам уруу ирж явна.

Илжиг болон дудранг унаж, эгэл даруухнаар ирнэ"»

гэсэн юм. ⁶Тэгээд шавь нар явж Есүсийн захисан ёсоор гүйцэтгэж, ⁷илжгийг дудрантай нь авчрахад тэд дээр нь дээлүүдээ тохоцгоолоо. Есүс илжгийг унав. ⁸Цугласан хүмүүсийн ихэнх нь дээл хувцсаа зам дээр

дэвсэхэд, зарим нь модноос мөчир огтлон зам дээр тавьж байлаа. ⁹Түүний өмнө хойно нь явж буй хурсан олон

—Давидын Хүүд Хосанна!

Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ!

Хамгийн дээдэд Хосанна!

гэж хашхиралдаж байлаа. ¹⁰Түүнийг Иерусалимд ороход бүх хотынхон үймэлдэж,

—Энэ хэн билээ? гэцгээв. ¹¹Олон түмэн

—Энэ чинь Галилын Назараас ирсэн эш үзүүлэгч Есүс байгаа юм гэж байв.

¹²Есүс сүмд орж ирээд худалдаачдыг болон худалдан авагсдыг бүгдийг нь хөөн гаргаж, зоос солигчдын ширээ, тагтаа худалдагсдын сандлыг хөмөрч орхиод, ¹³тэдэнд

—"Миний гэр бол залбирлын гэр гэж нэрлэгдэх болно" гэж бичигдсэн байдаг. Гэтэл та нар үүнийг дээрэмчдийн үүр болгож байна гэв. ¹⁴Сүмд байхад нь Түүн уруу сохор, доголон хүмүүс ирэхэд Тэр тэднийг эдгээжээ. ¹⁵Харин ахлах тахилч нар, хуулийн багш нар Түүний үйлдсэн гайхамшигт зүйлсийг болон сүм дотор

—Давидын Хүүд Хосанна! гэж хашхиралдах хүүхдүүдийг хараад ихэд дургүйцэн ¹⁶Түүнд

—Та эдний юу хэлж буйг сонсож байна уу? гэхэд Есүс

—Тийм ээ, "Нялх, хөхүүл хүүхдүүдийн амнаас магтаалыг Та Өөрийнхөө төлөө бэлдсэн" гэснийг та нар огт уншаагүй юм уу? гэв. ¹⁷Тэгээд тэднийг орхин хотоос гарч, Бетанд ирээд тэндээ хоноглов.

¹⁸Өглөө хот уруу буцахдаа Тэр өлссөн ажээ. ¹⁹Тэгээд замын хажуудах ганц инжрийн модыг хараад очтол навчнаас өөр юу ч олсонгүй. Есүс тэр модонд

—Чамд үр жимс хэзээ ч бүү ургаг гэхэд тэр даруй инжрийн мод хувхайрчээ. ²⁰Шавь нар нь үүнийг хараад мэл гайхаж

—Энэ инжрийн мод яаж ийм хурдан хувхайрав? гэцгээв. ²¹Есүс хариуд нь

—Үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нарт итгэл байгаад эргэлзэхгүй бол зөвхөн энэ инжрийн модонд тохиолдсоныг үйлдэх байтугай энэ ууланд ч

хүртэл "Дээш өргөгдөж тэнгист хаягд" гэж хэлсэн ч энэ нь биелэх болно. ²²Та нар итгэлтэйгээр залбиран гуйсан бүх зүйлсээ хүлээн авах болно гэж айлдав.

²³Түүнийг сүмд ороод сургаал зааж байхад нь ахлах тахилч нар ба олон түмний ахлагчид Түүн уруу ирж,

—Та ямар эрх мэдлээр эдгээрийг үйлдэнэ вэ? Хэн Танд энэ эрх мэдлийг өгөв? гэж асуухад ²⁴Есүс тэдэнд

—Би та нараас бас нэг зүйлийг асууя. Хэрэв Надад хариулбал, Би ч гэсэн ямар эрх мэдлээр эдгээрийг үйлддэгээ та нарт хэлье. ²⁵Иоханы баптисм хаанаас эхтэй байсан бэ? Тэнгэрээс үү, эсвэл хүмүүсээс үү? гэхэд тэд өөр хоорондоо хэлэлцэж

—Хэрэв бид "Тэнгэрээс" гэхивэл, Тэр бидэнд "Тэгвэл та нар яагаад түүнд итгээгүй юм бэ?" гэнэ дээ. ²⁶Хэрэв "Хүмүүсээс" гэвэл, энэ хурсан олон түмнээс бид айж байна. Учир нь тэд бүгдээрээ Иоханыг эш үзүүлэгч гэж үздэг шүү дээ гээд, ²⁷Түүнд

—Бид мэдэхгүй гэж хариулахад нь Есүс ч мөн тэдэнд хэлсэн нь

—Би ч гэсэн ямар эрх мэдлээр эдгээрийг үйлддэгээ та нарт хэлэхгүй. ²⁸Харин та нар юу гэж бодож байна? Нэгэн хүн хоёр хүүтэй байжээ. Тэр ууган хүү уруугаа очиж "Хүү минь, өнөөдөр явж, усан үзмийн тариалан дээр ажилла" гэсэнд, ²⁹хүү нь "За" гэсэн атлаа явсангүй. ³⁰Мөнөөх хүн удаах хүүдээ мөн тэгж хэлэхэд, хүү нь "Үгүй" гэжээ. Гэвч дараа нь гэмшиж, ажиллахаар явав. ³¹Тэр хоёрын аль нь эцгийнхээ хүслийг биелүүлсэн бэ? гэхэд, тэд

—Сүүлчийнх нь гэв. Есүс тэдэнд хандан

—Үнэнээр Би та нарт хэлье. Татвар хураагчид болоод янхнууд та нараас түрүүнд Бурханы хаанчлалд орох болно. ³²Учир нь Иохан зөвт байдлын замаар та нар уруу ирсэнд та нар түүнд итгээгүй. Харин татвар хураагчид болоод янхнууд түүнд итгэсэн юм. Та нар үүнийг үзэхдээ гэмшсэнгүй, дараа нь ч түүнд итгэсэнгүй.

³³Өөр сургаалт зүйрлэлийг сонсоцгоо. Нэгэн газрын эзэн усан үзмийн мод тариалж, түүнийгээ тойруулан хашаа барьж, дарс шахагч савыг суулгах нүх ухаж, цамхаг босгожээ. Тэгээд үүнийгээ тариаланчдад түрээслээд, аянд явж гэнэ. ³⁴Ургац хураах цаг болоход эзэн усан үзэм авчруулахаар боолуудаа усан үзмийн тариаланчид уруу илгээжээ. ³⁵Усан үзмийн

тариаланчид боолуудыг нь бариад нэгийг нь зодож, нөгөөг нь алж, гурав дахийг нь чулуугаар цохив. ³⁶Эзэн урьд явуулснаас ч олон тооны боолуудыг дахин илгээсэнд тэд мөн л адил ханджээ. ³⁷Гэвч дараа нь тэр "Тэд миний хүүг хүндэлнэ" гээд хүүгээ илгээв. ³⁸Харин тариаланчид хүүг хараад, өөр хоорондоо "Энэ чинь өв залгамжлагч байна. Ирэгтүн, түүнийг алж, өвийг нь булаацгаая" гэжээ. ³⁹Тэгээд тэд түүнийг бариад усан үзмийн тариалангийн гадна гаргаж хаяад, түүнийг алав. ⁴⁰Тэгвэл усан үзмийн тариалангийн эзэн хүрч ирээд, тэдгээр тариаланчдыг яах вэ? гэсэнд, ⁴¹тэд

—Тэр эзэн тэдгээр муу хүмүүсийг муугаар төгсгөж, түүнд хугацаанд нь усан үзмийг тушааж өгөх өөр тариаланчдад усан үзмийн тариалангаа түрээсэлнэ гэв. ⁴²Есүс тэдэнд

—"Барилгачдын голсон Чулуу булангийн тулгуур Чулуу болжээ.

Энэ нь Эзэнээс ирсэн бөгөөд

Бидний нүдэнд гайхалтай"

гэснийг та нар Судраас огт уншаагүй юу? ⁴³Иймээс Би та нарт хэлье. Бурханы хаанчлалыг та нараас авч, түүний үр жимсийг нь ургуулах үндэстэнд өгөх болно. ⁴⁴Хэн энэ чулуун дээр унана, тэр хүн хэдэн хэсэг хэмхрэх бөгөөд хэний дээр энэ чулуу унана, тэр нь хүнийг шороо мэт бутаргана гэж айлдав. ⁴⁵Фарисайчууд ба ахлах тахилч нар Түүний сургаалт зүйрлэлүүдийг сонсоод, Тэр өөрсдийнх нь тухай ярьсныг ойлгов. ⁴⁶Тэд Түүнийг барихыг санаархсан авч, олон түмнээс айж байлаа. Учир нь хүмүүс Түүнийг эш үзүүлэгч гэж үздэг байв.

[22]

¹Есүс тэдэнд сургаалт зүйрлэлээр дахин айлдсан нь

— ²Тэнгэрийн хаанчлалыг хүүгийнхээ хуримын найрыг хийсэн хаантай зүйрлэж болно. ³Хаан хуриманд уригдсан хүмүүсийг дуудуулахаар боолуудаа илгээсэн боловч, тэд ирэхийг хүссэнгүй. ⁴Тэр дахин "Уригдсан хүмүүст «Зоогийг бэлдлээ. Үхэр болон бордсон малаа гаргаж бүгдийг базааж бэлдлээ. Хуриманд морилон ир» гэж хэл" гээд өөр боолуудаа илгээв. ⁵Гэтэл тэд үл тоомсорлон өөрсдийнхөө мөрөөр явж, нэг нь тариан талбай уруугаа, нөгөө нь ажил уруугаа явав. ⁶Бусад нь хааны боолуудыг барин авч, доромжлон гутаагаад алжээ. ⁷Хаан уурлаад, цэргүүдээ илгээн тэдгээр алуурчдыг хөнөөгөөд, хотыг нь галдан шатаав. ⁸Тэгээд тэр боолууддаа

"Хурим бэлэн боллоо. Харин уригдагсан хүмүүс маань зохисгүй хүмүүс байжээ. ⁹Тиймээс та нар гол гудамжаар явж, тааралдсан болгоноо хуриманд морилон ирэхийг урь" гэхэд ¹⁰тэдгээр боолууд гудамжинд гарч тааралдсан сайн, муу хүмүүсийг бүгдийг цуглуулав. Хуримын танхим зоогийн зочдоор дүүрчээ. ¹¹Харин хаан зоогийн зочдыг харахаар орж ирээд хуримын хувцас өмсөөгүй нэгэн хүнийг хараад, ¹²түүнд "Анд минь, чи хуримын хувцасгүйгээр хэрхэн энд орж ирэв?" гэхэд тэр үг дуугүй байв. ¹³Тэгтэл хаан зарц нартаа "Түүний гар, хөлийг хүлээд гаднах харанхуйд хая. Тэнд тэр уйлж, шүдээ хавирах болно" гэж хэлжээ. ¹⁴Учир нь дуудагдсан нь олон хэдий ч сонгогдсон нь цөөхөн гэж ярив.

¹⁵Тэгээд фарисайчууд явж, Есүсийг хэлсэн үгэнд нь яаж унагаахаа хамтдаа зөвлөлдөв. ¹⁶Тэд өөрсдийн шавь нарыг херодынхонтой хамт Түүн уруу илгээж, ингэж асуулгалаа.

—Багш аа, бид Таны үнэнч хийгээд Бурханы замыг үнэнээр заадгийг тань, хэнийг ч ялгаварладаггүй тул хэнд ч тал засдаггүйг тань мэднэ. ¹⁷Тиймээс Та юу бодож байгаагаа бидэнд хэлээч? Бид Цезарьт албан татвар өгөх нь хуульд нийцэх үү, эсвэл үгүй юу? гэхэд ¹⁸Есүс тэдний хорон санааг мэдээд,

—Хоёр нүүрт хүмүүс ээ, та нар юунд Намайг сорино вэ? ¹⁹Надад татварт өгдөг зоосыг үзүүлээдэх гэв. Тэд Түүнд нэг денар өгсөнд, ²⁰Тэр

—Энэ хэний дүрс, бичээс вэ? гэж асуув. ²¹Тэд Түүнд

—Цезарийнх гэхэд Есүс

—Тэгвэл Цезарийн юмыг Цезарьт, Бурханы юмыг Бурханд өг гэлээ. ²²Үүнийг сонсоод тэд мэл гайхаж Түүнийг орхин одлоо.

²³Тэр өдөр (амилалт гэж байхгүй хэмээдэг) садукайчууд Түүн дээр ирж, Түүнээс асуусан нь

— ²⁴Багш аа, Мосе "Хэрэв эр хүн нь үр хүүхэдгүй үхвэл, түүний дүү эхнэртэй нь гэрлэж ахынхаа үр удмыг залгуулах ёстой" гэж хэлсэн. ²⁵Бидэнтэй хамт ах дүү долоон хүн байсан юм. Ууган нь эхнэр авч, үр удмаа үлдээлгүй үхэхэд дүү нь эхнэртэй нь гэрлэв. ²⁶Хоёр дахь, гурав дахиас авахуулан долоо дахь нь хүртэл ийнхүү үхэв. ²⁷Бүхний эцэст мөнөөх эмэгтэй ч үхэв. ²⁸Иймээс амилалт дээр мөнөөх эмэгтэй тэр долоогийн

хэнийх нь эхнэр болох вэ? Бүгд л түүнтэй гэрлэсэн шүү дээ гэхэд, ²⁹Есүс хариуд нь тэдэнд

—Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээс болж төөрөлдөж байна. ³⁰Амилалт дээр тэд гэрлэх ч үгүй, нөхөрт ч гарахгүй, харин тэнгэр дэх тэнгэр элч нартай адил болох юм. ³¹Харин үхэгсдийн амилалтын тухайд Бурханаас та нарт ³²"Би бол Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан" хэмээн айлдсаныг та нар уншаагүй хэрэг үү? Тэр бол үхэгсдийнх бус, харин амьдын Бурхан гэж хэлэв. ³³Үүнийг сонсоод олон түмэн Түүний сургаалд гайхаж байлаа.

³⁴Харин Есүс садукайчуудыг дуугүй болгосныг фарисайчууд сонсоод цуглав. ³⁵Тэдний нэг болох хуульч Түүнийг сорьж

— ³⁶Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ? гэж асуув. ³⁷Тэр түүнд

—"Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла". ³⁸Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. ³⁹Удаахи нь "Чи хөршөө өөрийн адил хайрла" гэсэнтэй адил юм. ⁴⁰Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм гэлээ.

⁴¹Фарисайчуудыг цуглах зуур Есүс тэднээс

— ⁴²Та нар Христийн тухай юу гэж боддог вэ? Тэр хэний хүү вэ? гэж асуухад тэд

—Давидынх гэцгээв. ⁴³Тэр тэдэнд

—Тэгвэл яагаад Давид Сүнсээр Түүнийг "Эзэн" гэж дуудаад,

⁴⁴"Эзэн, миний Эзэнд

«Би Чиний дайснуудыг хөл дор чинь тавих хүртэл

Миний баруун гарт залрагтун» гэсэн"

юм бэ? ⁴⁵Хэрэв Давид Түүнийг "Эзэн" хэмээн дууддаг бол Тэр яаж түүний хүү байх билээ? гэж айлдав. ⁴⁶Хэн ч хариуд нь Түүнд үг хэлж чадаагүй бөгөөд тэр өдрөөс хойш нэг ч хүн Түүнээс юм асуухыг зүрхэлсэнгүй.

[23]

¹Тэгээд Есүс цугласан олон түмэнд болоод шавь нартаа айлдсан нь

— ²Хуулийн багш нар, фарисайчууд Мосегийн суудалд суужээ. ³Тиймээс тэдний хэлсэн болгоныг та нар үйлд, сахь. Харин тэдний үйл хэргийн дагуу бүү үйлд. Учир нь тэд ярьдаг ч, түүнийгээ үйлддэггүй. ⁴Тэд хүнд ачаанууд баглаж хүмүүсийн мөрөн дээр тавьдаг атлаа өөрсдөө тэр ачаанд хуруугаа ч хүргэхийг хүсдэггүй. ⁵Харин тэд хамаг үйлсээ хүмүүст харуулахын тулд хийдэг бөгөөд тэд магнайн ба гарын сахиусаа өргөсгөж, унжлагаа уртасгадаг. ⁶Тэд найр наадмын тэргүүн эгнээнд, синагогуудад тэргүүн суудалд суух, ⁷зах зээл дээр хүндлүүлэн мэндлүүлэх, "Багш аа" гэж хүмүүсээр дуудуулах дуртай аж. ⁸Харин та нар "Багш аа" гэж битгий дуудуул. Та нарын Багш Ганц бөгөөд та нар бүгд ахан дүүс билээ. ⁹Газар дээр хэн нэгнийг эцгээ болгож битгий дууд. Учир нь та нарын Эцэг Ганц бөгөөд Тэр тэнгэрт буй. ¹⁰Та нар удирдагчид гэж битгий дуудуул. Та нарын Удирдагч Ганц бөгөөд Тэр нь Христ юм. ¹¹Харин та нарын дундах хамгийн агуу нь зарц болог. ¹²Өөрийгөө өргөмжлөгч нь дорд болгогдох бөгөөд өөрийгөө дорд болгогч нь өргөмжлөгдөх болно.

¹³Гэвч хоёр нүүрт хуулийн багш нар болон фарисайчууд та нар золгүй еэ! Юу гэвэл та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хаадаг. Та нар өөрсдөө ордог ч үгүй, орох хүмүүсийг ч оруулдаггүй байна. ¹⁴[Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Юу гэвэл, та нар бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэрийг цөлмөдөг атлаа удаан залбирах дүр үзүүлдэг тул та нар илүү хүнд шийтгэл хүлээнэ.]

¹⁵Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Юу гэвэл, та нар ганц хүнийг ч гэсэн сүсэгтнээ болгохын тулд тэнгис газаргүй хөндлөн гулд явдаг. Түүнийг сүсэгтэн болоход та нар түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын хүү болгодог ажээ.

¹⁶Сохор газарчид аа, та нар золгүй еэ! Та нар "Хэн сүмээр тангараглана, тэр нь юу ч биш. Харин сүмийн алтаар тангараглагч түүнд үүрэг оногддог" гэдэг. ¹⁷Мунхаг, сохор хүмүүс ээ, аль нь илүү чухал вэ? Алт уу, эсвэл алтыг ариусгадаг сүм үү? ¹⁸"Хэн тахилын ширээгээр тангараглана, тэр нь юу ч биш. Харин дээрх өргөлөөр нь тангараглагч түүнд үүрэг оногддог" гэдэг. ¹⁹Сохор хүмүүс ээ, аль нь илүү чухал вэ? Өргөл үү, эсвэл өргөлийг ариусгадаг тахилын ширээ юу? ²⁰Иймээс тахилын ширээгээр тангараглагч нь тахилын ширээгээр болон дээр нь байгаа бүхнээр тангараглаж байгаа юм. ²¹Сүмээр тангараглагч нь сүмээр болон түүн дотор оршдог Түүгээр

тангараглаж байгаа юм. ²²Тэнгэрээр тангараглагч нь Бурханы сэнтийгээр болон дээр нь залрагч Түүгээр тангараглаж буй.

²³Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар гаа, гоньд, зирааны аравны нэгийг өгдөг атлаа хуулийн чухал нөхцлүүд болох шударга ёс, өршөөл, итгэлтэй байдлыг орхигдуулдаг. Чухамдаа бусдыг нь ч орхилгүй, эдгээрийг биелүүлэх ёстой байсан. ²⁴Шумуулыг шүүгээд тэмээг залгичихдаг сохор газарчид аа!

²⁵Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар аяга тавагнахаа гадна талыг нь цэвэрлэдэг хэдий ч дотор нь дээрэм, хувийн сонирхол дүүрэн аж. ²⁶Сохор фарисай та эхлээд аяга, савныхаа дотор талыг цэвэрлэ. Тэгвэл гаднах нь ч мөн цэвэрхэн болно.

²⁷Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар бол цагаанаар будсан булшнууд шиг гаднаа гоё сайхан харагддаг хэдий ч дотроо үхэгсдийн яс болоод бузар бүхнээр дүүрэн аж. ²⁸Та нар ч гэсэн хүмүүсийн өмнө гаднаа зөвт хүмүүс мэт харагдавч, дотроо хоёр нүүрт зан болон хууль бус явдлаар дүүрэн аж.

²⁹Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар эш үзүүлэгчдийн бунханг барьж, зөвт хүмүүсийн хөшөөг чимдэг. ³⁰Тэгээд "Хэрэв бид эцэг өвгөдийнхөө үед амьдарч байсан бол эш үзүүлэгчдийн цусыг урсгахад тэдний хамсаатан болохгүй л байсан" гэдэг. ³¹Тэгснээрээ та нар өөрсдийгөө эш үзүүлэгчдийн амийг бүрэлгэсэн хүмүүсийн хөвгүүд гэдгээ гэрчилдэг. ³²Та нар өвөг эцгүүдийнхээ гэмийн хэмжээг дүүргэ. ³³Могойнууд аа, хорт могойн удам аа, тамын шийтгэлээс та нар яаж зугтаах вэ? ³⁴Гиймээс, үзэгтүн. Би та нар уруу эш үзүүлэгчид ба мэргэн хүмүүс, хуулийн багш нарыг илгээж байна. Та нар тэдний заримыг алж, цовдолж, заримыг нь өөрсдийн синагогуудад ташуурдаж, хотоос хотод тэднийг хавчин мөшгөх болно. ³⁵Зөвт нэгэн Абелын цуснаас авахуулаад сүм болоод тахилын ширээ хоёрын хооронд та нарын алсан Берехиагийн хүү Зехариагийн цус хүртэлх газар дээр урссан бүх зөвт хүний цус та нар дээр ирнэ. ³⁶Үнэнээр Би та нарт хэлье. Энэ бүх юмс энэхүү үеийнхэн дээр ирнэ.

³⁷Иерусалим аа, Иерусалим аа, чи эш үзүүлэгчдийг алж, чам уруу илгээгдсэн хүмүүс уруу чулуу нүүлгэдэг. Тахиа дэгдээхийнүүдээ далавчин доороо бөөгнүүлдэг шиг Би чиний хүүхдүүдийг цуглуулахыг хичнээн ч удаа хүслээ дээ. Харин та нар хүсээгүй. ³⁸Харагтун, гэр чинь та нарт хоосон

үлдэж байна. ³⁹Учир нь Би та нарт хэлье. Та нар үүнээс хойш "Эзэний нэрээр Ирэгч ерөөлтэй еэ!" гэж хэлтлээ Намайг огт харахгүй.

[24]

¹Есүсийг сүмээс гарч явах үед шавь нар нь Түүнд сүмийн барилгыг үзүүлэхээр хүрч ирэв. ²Тэр тэдэнд

—Та нар энэ бүгдийг харахгүй байна уу? Үнэнээр Би та нарт хэлье. Энд нэг ч чулуу нөгөө чулуун дээрээ үлдэхгүй бүгд нурах болно гэв.

³Түүнийг Чидун ууланд сууж байхад шавь нар Түүн уруу хувьчлан ирж,
—Эдгээр зүйл чинь хэзээ болох юм бэ? Таны заларч ирэхэд болон үеийн төгсгөлд ямар шинж тэмдэг байх вэ? Бидэнд хэлээч гэсэнд ⁴Есүс хариуд нь

—Хэн нэг нь та нарыг төөрөлдүүлэх вий, болгоомжил. ⁵Учир нь олон хүн "Би бол Христ" хэмээн Миний нэрээр ирж, олныг төөрөлдүүлнэ. ⁶Та нар дайн болоод дайны сураг чимээг удахгүй сонсоно. Айж сандруузай. Тэдгээр нь зайлшгүй болох учиртай бөгөөд төгсгөл нь хараахан биш юм. ⁷Үндэстэн үндэстнийхээ эсрэг, хаанчлал хаанчлалынхаа эсрэг босох бөгөөд энд тэндгүй өлсгөлөн болоод газар хөдлөлт болно. ⁸Харин энэ бүгд нь төрөх өвдөлтийн эхэн юм. ⁹Тэгэхэд хүмүүс та нарыг зовлон гамшигт тушааж, та нарыг ална. Миний нэрээс болж та нарыг бүх үндэстэн үзэн ядах болно. ¹⁰Тэр үед олон хүн бүдрэх бөгөөд нэг нэгнээ тушааж, үзэн ядна. ¹¹Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөлдүүлнэ. ¹²Ёс бус байдал өссөнөөс болж олонх хүмүүсийн хайр хөрнө. ¹³Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно. ¹⁴Хаанчлалын энэхүү сайн мэдээ бүх үндэстэнд гэрчлэл болж дэлхий даяар тунхаглагдана. Тэгээд төгсгөл ирнэ.

¹⁵Иймд эш үзүүлэгч Даниелын хэлсэн хоосролын бузар юм ариун газар байхыг та нар харвал (уншигч нь ойлгог), ¹⁶Иудейд байгсад нь уул уруу зугтааг. ¹⁷Дээвэр дээр байгаа нь гэрээсээ юмаа авч гарах гэж доош бүү бууг. ¹⁸Талбайд байгаа нь дээлээ авахаар бүү буцаг. ¹⁹Харин тэр өдрүүдэд жирэмсэн эмэгтэйчүүд болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд золгүй еэ! ²⁰Та нарын зугталт нь өвөл, эсвэл амралтын өдөр таарахгүйн тулд залбир. ²¹Учир нь ертөнцийн эхнээс өнөөг хүртэл болоогүй, мөн хэзээ ч болохгүй агуу их гай гамшиг болно. ²²Хэрэв тэр өдрүүдийг богиносгоогүйсэн бол нэг ч махан бие аврагдахгүй байх байсан. Харин сонгогдогсдын төлөө тэр

өдрүүдийг богиносгоно. ²³Хэрэв хэн нэгэн та нарт "Харагтун, Христ энд байна", эсвэл "Тэнд" гэвэл түүнд бүү итгэ. ²⁴Хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, хэрэв боломжтой бол сонгогдогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд, гайхамшгуудыг харуулах болно. ²⁵Үзэгтүн. Би та нарт урьдаас хэлсэн. ²⁶Тиймээс хэрэв тэд та нарт "Хараач, Тэр цөлд байна" гэвэл бүү оч, эсвэл "Хараач, Тэр дотоод өрөөнд байна" гэвэл бүү итгэ. ²⁷Аянга зүүн зүгээс цахиж, баруун зүгт ч гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн заларч ирэх нь тийм байх болно. ²⁸Хүүр байгаа газар тас шувууд цуглардаг.

²⁹Гэвч гамшгийн тэр өдрүүдийн дараа тэр даруй нар харанхуйлж, сар гэрэлтэхгүй, одод тэнгэрээс унаж, тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно. ³⁰Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг харна. ³¹Тэр тэнгэр элч нараа их бүрээн дуугаар илгээхэд тэд сонгогдогсдыг нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл дөрвөн салхинаас цуглуулах болно.

³²Одоо инжрийн модноос сургаалт зүйрлэлийг сурч ав. Инжир модны мөчир хэдийнээ зөөлөрч, навчсаа зулзагалуулахад зун ойртжээ гэдгийг та нар мэддэг. ³³Түүнчлэн та нар энэ бүхнийг хараад, Түүнийг ойрхон байгааг, үүдэн дээр чинь байгааг та нар бас мэдэгтүн. ³⁴Үнэнээр Би та нарт хэлье. Энэ бүхнийг тохиолдохоос нааш энэ үеийнхэн үгүй болохгүй. ³⁵Тэнгэр газар үгүй боловч, Миний үгс огтхон ч үгүй болохгүй.

³⁶Харин тэр өдөр, цагийн тухайд хэн ч мэдэхгүй. Тэнгэрийн элч ч, Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ. ³⁷Учир нь Хүний Хүүгийн залран ирэх нь Ноагийн өдрүүдтэй адил байх юм. ³⁸Үерийн өмнөх өдрүүдэд буюу Ноаг хөвөгч авдарт орох өдөр хүртэл тэд идэж ууж, гэрлэж, нөхөрт гарцгааж байлаа. ³⁹Үер бууж бүгдийг хаман одох хүртэл тэд ойлгоогүй юм. Хүний Хүүгийн залран ирэх нь түүнчлэн байх болно. ⁴⁰Тэр үед хоёр хүн талбайд байхад нэгийг нь авч, нөгөөг нь үлдээнэ. ⁴¹Хоёр эмэгтэйг тээрэмдэж байхад нэгийг нь авч, нөгөөг нь орхино. ⁴²Тиймээс Эзэн тань ямар өдөр ирэхийг та нар мэдэхгүй тул сонор сэргэг бай. ⁴³Харин үүнийг мэд. Хэрэв гэрийн тэргүүлэгч шөнийн хэдэн цагт хулгайч ирэхийг мэдэж байсан бол соргог байж, гэрээ ухуулахгүй байх байсан. ⁴⁴Тиймээс та нар бас бэлэн бай. Хүний Хүү та нарын бодоогүй цаг мөчид ирнэ.

⁴⁵Эзэн нь зарц нартаа цагт нь хоол ундыг өгүүлэхээр гэрийн даамлаар тавьсан итгэмжит ухаалаг боол нь хэн бэ? ⁴⁶Түүнийг тийн биелүүлж байхад эзэн нь ирээд харвал, тэр боол ерөөлтэй еэ! ⁴⁷Үнэнээр Би та нарт хэлье, эзэн хамаг эзэмшил хөрөнгөө түүнд даатгана. ⁴⁸Харин муу боол нь зүрхэндээ "Эзэн маань удаан хугацаагаар ирэхгүй" гээд\v ⁴⁹өөрийн анд нөхөд болох боолуудаа зодож, архичидтай идэж ууж эхэлбэл, ⁵⁰эзнээ ирнэ гэж хүлээгээгүй өдөр, мэдэхгүй цагт нь мөнөөх боолын эзэн ирж, ⁵¹түүнийг үхтэл нь зодож, хоёр нүүртэнгүүдтэй хамт нэг газарт байрлуулна. Тэгээд тэнд уйлж, шүдээ хавирах болно.

[25]

¹Мөн тэнгэрийн хаанчлал нь шинэ хүргэнийг угтахаар дэнлүүгээ аваад гарсан арван охинтой төстэй юм. ²Тэдний тав нь мунхаг, тав нь ухаалаг болой. ³Мунхгууд нь дэнлүүгээ авахдаа тосыг нь авсангүй. ⁴Харин ухаалагууд нь дэнлүүгээ тос хийсэн савны хамт авсан байлаа. ⁵Хүргэн ирэхгүй удсан тул тэд бүгд үүрэглэж, унтаж эхлэв. ⁶Гэтэл шөнө дөлөөр хашхирах дуун гарч "Хараач, хүргэн байна. Түүнийг угтаж авцгаа" гэлээ. ⁷Нөгөө охид бүгдээрээ босож дэнлүүгээ бэлдэв. ⁸Мунхгууд нь ухаалаг охидод "Бидэнд тосноосоо өгөөч. Бидний дэнлүү бөхөх нь" гэсэнд, ⁹ухаалагууд нь "Бидэнд ч, та нарт ч огт хүрэлцэхгүй. Оронд нь худалдаачин уруу очиж, тос худалдаж ав" гэжээ. ¹⁰Тэднийг худалдаа хийхээр явсан хооронд хүргэн ирээд, бэлэн болсон хүмүүс хүргэний хамт хуримын найрт оров. Тэгээд хаалгаа хаажээ. ¹¹Дараа нь бусад охид нь ирж "Эзэн, эзэн, бидэнд онгойлгож өгөөч" гэхэд ¹²харин тэр хариуд нь "Үнэнээр би та нарт хэлье. Би та нарыг танихгүй" гэв. ¹³Иймд та нар соргог бай. Учир нь та нар тэр өдрийг ч, цагийг ч мэдэхгүй.

¹⁴Энэ нь холын аянд гарахдаа боолуудаа дуудаад, эзэмшлээ тэдэнд даатгаж буй нэгэн хүнтэй адил болой. ¹⁵Тэр хүн нэгэнд нь тав, нөгөөд нь хоёр, өөр нэгэнд нь нэг талант өгчээ. Ингэхдээ хүн нэг бүрд чадварынх нь дагуу өгсөн аж. Тэгээд аяндаа явж гэнэ. ¹⁶Таван талант авсан нь тэр даруй явж, түүгээрээ худалдаа хийгээд таван талант нэмж олов. ¹⁷Үүний нэгэн адил хоёр талант авсан нь мөн хоёр талант нэмж олжээ. ¹⁸Харин нэг талант авсан нь явж, газар ухаад эзнийхээ мөнгийг нуужээ. ¹⁹Удаан хугацааны дараа өнөөх боолуудын эзэн ирж, тэдэнтэй тооцоо бодож гэнэ. ²⁰Таван

талант авсан боол ирээд илүү таван талант өгч, "Эзэн, та надад таван талант олгосон. Би таван талант нэмж олсон" гэв. ²¹Эзэн нь түүнд "Сайн байна, итгэмжит сайн боол минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор" гэжээ. ²²Хоёр талант авсан боол ирээд, "Эзэн, та надад хоёр талант олгосон. Би хоёр талант нэмж олов" гэхэд\v 23 эзэн нь түүнд "Сайн байна, итгэмжит сайн боол минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор" гэжээ. ²⁴Мөн нэг талант авсан боол ирж, "Эзэн, би таныг үр суулгаагүй газраас хадаж авдаг, юу ч цацаагүй газраас түүж авдаг хатуу хүн гэдгийг мэднэ. ²⁵Би айсан тул явж таны талантыг газарт нуучихсан. Хар, таны юм энэ байна" гэв. ²⁶Эзэн нь түүнд "Муу залхуу боол, чи намайг үр суулгаагүй газраас хадаж авдаг, юу ч цацаагүй газраас түүж авдгийг мэддэг гэнэ ээ? ²⁷Тэгвэл чи миний мөнгийг мөнгө хүүлэгчид хадгалуулах ёстой байсан юм. Тэгсэн бол буцаж ирээд өөрийнхийгөө хүүтэй нь авах байсан юм. ²⁸Түүнээс нэг талантыг авч арван таланттай хүнд өг. ²⁹Учир нь хэнд байна, түүнд илүү ихээр өгөгдөнө. Тэр нэгэнд элбэг дэлбэг байх болно. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс авагдах болно. ³⁰Энэ зохисгүй боолыг харанхуйд хөөж гарга! Тэр тэнд уйлж, шүдээ хавирах болно" гэж хэлэв.

³¹Хүний Хүү алдраа дуурсган бүх тэнгэр элч нарынхаа хамт ирж Өөрийн сүр жавхланта сэнтийндээ залрах болно. ³²Тэр бүх үндэстнийг өмнөө цуглуулж, хоньчин хонио ямаанаас тусгаарладаг шиг Тэр тэднийг нэг нэгнээс нь тусгаарлаад, ³³хонио Өөрийн баруунтайд, ямааг зүүнтэйд байлгана. ³⁴Тэгээд Хаан Өөрийн баруунтайд байгсдад хандан хэлэх нь "Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай. ³⁵Учир нь Намайг өлсөж байхад та нар Надад идэх юм өгсөн. Намайг цангаж байхад уух юм өгсөн, Намайг харь хүн байтал урьж оруулсан, ³⁶нүцгэн байхад минь Намайг хувцасласан, өвчтэй байхад минь Намайг эргэж байсан, шоронд байхад минь Над уруу ирсэн билээ" гэхэд, ³⁷зөвт хүмүүс Түүнд "Эзэн, бид хэзээ Таныг өлсөж байхыг тань хараад хооллож, цангаж байхыг тань хараад уух юм өгсөн бэ? ³⁸Хэзээ бид Таныг харь газрынх байсныг тань хараад урьж оруулан, нүцгэн байхыг тань хараад хувцасласан бэ? ³⁹Хэзээ бид Таныг өвчтэй байхыг тань хараад эргэж, шоронд байхыг тань хараад очсон юм бэ?" гэх болно. ⁴⁰Тэгэхэд Хаан тэдэнд "Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн

маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг" гэж хэлнэ.

⁴¹Тэгээд Тэр Өөрийн зүүнтэйд байгсдад хандан "Хараагдагсад аа, Надаас зайл. Дявол болоод түүний тэнгэр элч нарт нь бэлтгэсэн мөнх галд ор.

⁴²Учир нь та нар Намайг өлсөж байхад идэх юм өгөөгүй, цангаж байхад минь уух юм өгөөгүй, ⁴³Намайг харь газрынх байхад урьж оруулаагүй, нүцгэн байхад минь хувцаслаагүй, өвчтэй болоод шоронд байхад минь Над уруу ирээгүй" гэж хэлнэ. ⁴⁴Тэд мөн адил "Эзэн, хэзээ бид Таныг өлсөж, цангаж, харь газрын, нүцгэн, өвчтэй, шоронд байхыг чинь хараад Танд үйлчлээгүй юм бэ?" гэх болно. ⁴⁵Тэр хариуд нь "Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр хамгийн дордод нь ийнхүү үйлдээгүй бол Надад ч хийгээгүй хэрэг" гэж хэлнэ. ⁴⁶Тэд мөнх шийтгэлд, харин зөвт хүмүүс нь мөнх аминд орох юм гэж айлдлаа.

[26]

¹Есүс энэ бүх үгсээ хэлж дуусаад шавь нартаа

— ²Хоёр хоногийн дараа Дээгүүр Өнгөрөх баяр болохыг та нар мэднэ. Хүний Хүү цовдлуулахаар тушаагдана гэлээ. ³Тэр үед тэргүүн тахилч Каиафын ордонд ахлах тахилч нар болон олны ахлагчид цуглаад, ⁴Есүсийг зальжин аргаар барьж, алахаар хуйвалдацгаав. ⁵Гэхдээ тэд

—Олон түмний дунд үймээн гаргахгүйн тулд баярын үеэр болохгүй хэмээцгээв.

⁶Есүсийг Бетанд, уяман өвчтэй Симоны гэрт байхад ⁷их үнэтэй тос бүхий гөлтгөнөн сав барьсан эмэгтэй Түүн дээр ирээд, Түүнийг тухлан суугаад хооллох үед толгой дээр нь тосоо цутгав. ⁸Шавь нар үүнийг хараад уурлаж,

—Юунд ийм үрэлгэн байна вэ? ⁹Энэ тосыг өндөр үнээр зарж, мөнгийг нь ядууст өгч болох байлаа шүү дээ гэцгээв. ¹⁰Харин Есүс үүнийг мэдээд, тэдэнд

—Та нар энэ эмэгтэйд юунд төвөг удна вэ? Тэр Надад сайныг үйлдэв. ¹¹Учир нь та нар үргэлж ядуустай цуг байна. Харин та нар Надтай үргэлж цуг байхгүй. ¹²Энэ эмэгтэй биен дээр минь үнэртнийг цутгаснаараа Намайг оршуулгад бэлтгэж байгаа юм. ¹³Үнэнээр Би та нарт хэлье. Энэхүү сайн

мэдээ бүх дэлхийн хаа ч тунхаглагдсан, энэ эмэгтэйг дурсаж, түүний үйлс яригдах болно гэлээ.

¹⁴Тэр үед арван хоёрын нэг болох Искаротын Иудас ахлах тахилч нар уруу очиж,

— ¹⁵Түүнийг та нарт тушаавал та нар надад юу өгмөөр байна? гэхэд тэд түүнд гучин мөнгөн зоос дэнслээд өгөв. ¹⁶Тэр мөчөөс эхлэн тэр Есүсийг барьж өгөх аятай боломжийг хайв.

¹⁷Исгээгүй Талхны баярын эхний өдөр шавь нар Түүн уруу ирж,

—Танд зориулан Дээгүүр Өнгөрөх баярын зоогийг хаана бэлдүүлэхийг Та хүсэж байна? гэж асуухад ¹⁸Тэр

—Хот уруу, нэгэн хүн дээр оч. Түүнд "Багш «Миний цаг ойртож байна. Би танайд шавь нартайгаа хамт Дээгүүр Өнгөрөх баярыг тэмдэглэнэ» гэсэн" гэж хэл гэв. ¹⁹Шавь нар нь Есүсийн айлдсанаар үйлдэж, Дээгүүр Өнгөрөх баярт бэлдэв. ²⁰Орой болоход Тэр шавь нарын хамт ширээнд тухлан сууж байлаа. ²¹Тэднийг зооглон байх үед Тэр

—Үнэнээр Би та нарт хэлье. Та нарын нэг чинь Надаас урвана хэмээхэд ²²тэд ихэд гуниглан, дор бүрдээ л Түүнээс

—Би биш биз дээ, Эзэн минь! гэцгээв. ²³Тэр

—Миний хамт тавганд гараа дүрэгч нь Надаас урвах болно. ²⁴Хүний Хүү Өөрийнх нь тухай бичигдсэнчлэн явна. Харин Хүний Хүүг бариулах тэр хүн золгүй еэ! Тэр хүн төрөөгүй байсан бол дээр байх байсан гэлээ. ²⁵Есүсээс урвасан Иудас

—Би биш биз дээ, Рабби? гэхэд Тэр

—Чи өөрөө хэллээ гэв.

²⁶Тэднийг зооглон байх үед Есүс хэсэг талх аваад ерөөсний дараа, хуваан шавь нартаа өгөөд,

—Май, ид. Энэ бол Миний бие гэлээ. ²⁷Тэгээд Тэр аяга авч, талархлаа өргөөд, тэдэнд өгөнгөө

—Үүнээс та нар бүгдээрээ ууцгаа. ²⁸Учир нь энэ бол нүглүүдийн уучлалын тулд олны төлөө урсгах гэрээний Миний цус. ²⁹Харин Би та нарт хэлье. Үүнээс хойш Би энэ усан үзмийн дарсыг та нартай хамт Эцэгийнхээ хаанчлалд дахин шинээр уух өдрийг хүртэл ер уухгүй гэв.

³⁰ Тэд магтуу дуулсныхаа дараа, тэд Чидун уул өөд явцгаав.

³¹ Тэгэхэд Есүс тэдэнд

—Та нар энэ шөнө Надаас болж бүгд бүдрэх болно. Учир нь "Би хоньчинг цохиж унагахад хонин сүрэг тарж бутарна" гэж бичигдсэн билээ.

³² Харин Би амилуулагдсаны дараа, та нараас өмнө Галилд очно гэв. ³³ Петр Түүнд

—Танаас болж бүгд бүдэрлээ ч, би хэзээ ч бүдрэхгүй гэв. ³⁴ Есүс

—Үнэнээр Би чамд хэлье. Энэ шөнө азарган тахиа донгодохоос өмнө чи Намайг гурван удаа үгүйсгэнэ дээ гэв. ³⁵ Тэгтэл Петр Түүнд

—Би хичнээн Тантай хамт үхэх ёстой болсон ч, Таныг үгүйсгэхгүй гэхэд шавь нар бүгдээрээ бас тэгж хэлцгээв.

³⁶ Есүс тэдний хамт Гетсемани хэмээн нэрлэдэг газар ирж, шавь нартаа

—Намайг тэнд очиж залбирах зуур энд сууцгааж бай гээд, ³⁷ Тэр Өөрийн хамт Петр болон Зебедеен хоёр хүүг авч явав. Тэр зовж, шаналж эхлэв.

³⁸ Тэгээд тэдэнд

—Сэтгэл минь үхтлээ зовж байна. Энд үлдээд, Надтай хамт сэргэг байцгаа гэв. ³⁹ Тэр тэднээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж,

—Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог гэж залбирлаа. ⁴⁰ Тэгээд Тэр шавь нар уруугаа ирж, тэдний унтаж байхыг хараад, Петр

—Та нар чинь Надтай хамт ганцхан цаг ч сэргэг байж чадахгүй улс уу?

⁴¹ Соригдохгүйн тулд сэргэг бай, залбир. Сүнс хүсэж байна, харин махан бие сул дорой юм гэв. ⁴² Тэр дахин хоёр дахь удаагаа явж, залбиран

—Эцэг минь, хэрэв Би үүнийг уухаас нааш энэ нь өнгөрөхгүй юм бол, Таны хүсэл биелэг гэлээ. ⁴³ Есүс дахин ирж, тэдний унтаж байхыг харав. Тэдний нүд анилдаж байлаа. ⁴⁴ Тэр тэднийг дахин орхин холдон явж, өмнө хэлснийгээ хэлж, гурав дахь удаагаа залбирав. ⁴⁵ Тэгээд Тэр шавь нар дээрээ ирж,

—Та нар одоо хүртэл унтаж, амарсаар байна уу? Харагтун. Цаг ойртчихлоо. Хүний Хүү нүгэлтнүүдийн гарт орж байна. ⁴⁶ Бос, явцгаая. Харагтун. Намайг бариулагч ойртон ирлээ гэлээ.

⁴⁷Түүнийг ийн ярьж байх зуур арван хоёрын нэг болох Иудас ахлагч тахилч нар болон олон түмний ахлагчдаас илд, шийдэмтэй бөөн хүмүүсийг дагуулан хүрч ирэв. ⁴⁸Түүнээс урваж байсан нэгэн нь тэдэнд

—Би хэнийг үнсэнэ, Тэр нь мөн. Түүнийг барь хэмээн битүү дохио өгчээ.

⁴⁹Тэр даруй Есүс уруу очиж,

—Амар байна уу, Рабби? гээд Түүнийг үнсэв. ⁵⁰Есүс түүнд

—Анд минь, чи яах гэж ирэв? гэлээ. Тэгээд тэд ирээд Есүсийг барьж аваад баривчлав. ⁵¹Есүстэй хамт байсан хүмүүсийн нэг нь гараа сунган илдээ сугалаад тэргүүн тахилчийн боолыг цохиж, чихийг нь тас цавчжээ.

⁵²Есүс түүнд

—Илдээ хуйнд нь хий. Илд агсагч бүхэн илдээр хөнөөгдөнө. ⁵³Арван хоёр легионоос олон тэнгэр элчийг одоохон Өөр уруугаа илгээхээр би Эцгээсээ гуйж чадахгүй гэж чи бодож байна уу? ⁵⁴Тэгвэл энэ нь болох ёстой гэсэн Судар яаж биелэгдэх билээ? гэв. ⁵⁵Тэр үед Есүс хурсан олонд

—Та нар Намайг дээрэмчин барихтай адил санан илд, шийдэмтэй ирээ юү? Өдөр бүр сүмд байж сургаал заадаг байхад минь та нар Намайг бариагүй. ⁵⁶Харин энэ бүхэн нь эш үзүүлэгчдийн Судар биелэгдэхийн тул болов гэв. Тэгтэл бүх шавь нар Түүнийг орхин зугтав.

⁵⁷Есүсийг барьсан хүмүүс Түүнийг тэргүүн тахилч Каиафт хүргэлээ. Тэнд хуулийн багш нар болон ахлагчид цугласан байв. ⁵⁸Харин Петр мөн Түүнийг алсуур тэргүүн тахилчийн хашаа хүртэл дагаж, дотогш орон, зарц нарын хамт юу болохыг харж суув. ⁵⁹Ахлах тахилч нар хийгээд бүх Зөвлөл Есүсийг хөнөөхийн тулд Түүний эсрэг худал гэрчлэл олохыг оролдсоор байлаа. ⁶⁰Хэдийгээр хуурамч гэрч нар олноор гарч ирсэн боловч, тэд юу ч олсонгүй. Харин сүүлд нь хоёр хүн гарч ирээд,

— ⁶¹Энэ хүн "Би Бурханы сүмийг устгаад, гурав хоногийн дотор дахин барьж чадна" гэж хэлж байсан гэв. ⁶²Тэргүүн тахилч босож, Түүнд

—Чамд хариулах юм алга уу? Эдгээр хүмүүс Чиний эсрэг юу гэж гэрчилж байгаа юм бэ? гэлээ. ⁶³Гэвч Есүс дуугүй байлаа. Тэгтэл тэргүүн тахилч Түүнд

—Чамайг амьд Бурханаар тангараглуулья. Чи Бурханы Хүү, Христ мөн юм уу? Бидэнд хэлээч гэв. ⁶⁴Есүс түүнд

—Та ч өөрөө хэллээ. Харин Би та нарт хэлье. Та нар үүнээс хойш Хүчит Нэгэний баруун талд залрах Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр залран ирэхийг харах болно гэж айлдав. ⁶⁵Тэргүүн тахилч дээлээ хүү татан,

—Тэр Бурханыг доромжлов. Бидэнд өөр гэрчийн хэрэг байна уу? Үзэгтүн. Та нар доромжлолыг сонсоцгоолоо. ⁶⁶Та нар юу гэж бодож байна? гэхэд тэд

—Тэр үхэх ёстой гэцгээлээ. ⁶⁷Тэд Түүний нүүр уруу нулимж, Түүнийг нударгалан, зарим нь алгадаад,

— ⁶⁸Чамайг хэн цохьсныг эш үзүүлээдэх, эрхэм Христ ээ? гэцгээв.

⁶⁹Петрийг гадаа хашаан дотор сууж байтал нэгэн шивэгчин түүнд ойртон ирж,

—Чи ч бас Галилын Есүстэй хамт байсан шүү дээ гэхэд ⁷⁰харин тэр бүгдийн өмнө үүнийг үгүйсгээд,

—Чиний юу ярьж байгааг би ойлгохгүй байна гэв. ⁷¹Петрийг хашааны хаалга хавьд ирэхэд өөр шивэгчин түүнийг хараад, тэнд байсан хүмүүст

—Энэ хүн Назарын Есүстэй хамт байсан гэж хэлэв. ⁷²Тэр дахин үүнийг үгүйсгэж,

—Би энэ хүнийг танихгүй хэмээн ам өчгөө өгөв. ⁷³Тэгтэл удалгүй, тэнд зогсож байсан хүмүүс ирээд

—Чи тэдний нэг гарцаагүй мөн. Ярианаас чинь л илт байна гэлцэв. ⁷⁴Петр хараал тавин тангараглаж,

—Би энэ хүнийг танихгүй гэлээ. Тэр даруйд тахиа донгодов. ⁷⁵Тэгтэл Петр «Тахиа донгодохоос өмнө чи Намайг гурвантаа үгүйсгэнэ дээ» гэж айлдаж байсан Есүсийн үгийг санаад, гадагшаа гарч яван, гашуунаар уйлав.

[27]

¹ Өглөө эрт ахлагч тахилч нар болон олны ахлагчид Есүсийг алуулахаар зөвлөлдөөд, ² Түүнийг хүлж, авч яваад захирагч Пилатад тушаав.

³ Түүнээс урвасан Иудас Түүний яллагдсаныг хараад харуусаж, гучин мөнгөн зоосоо ахлах тахилч нар болоод ахлагчдад буцаан өгч,

— ⁴Би гэм зэмгүй цуснаас урваснаараа нүгэл үйлдлээ гэхэд тэд

—Энэ бидэнд хамаагүй, өөрөө мэд гэв. ⁵Иудас мөнгөн зооснуудыг ариун газарт чулуудаад, явж, өөрийгөө дүүжилжээ. ⁶Ахлах тахилч нар мөнгөн зооснуудыг авч,

—Энэ нь цусны үнэ тул үүнийг сүмийн эрдэнэсийн санд хийх нь ёс бус юм гэв. ⁷Тэд зөвлөлдөөд тэр мөнгөөр Ваарчны Талбайг худалдан авч, харийн хүмүүсийг оршуулдаг газар болгов. ⁸Тиймээс тэр талбай энэ өдрийг хүртэл «Цуст Талбай» хэмээгдэх болжээ. ⁹Тийнхүү эш үзүүлэгч Иеремиагаар хэлүүлсэн нь биелэгдсэн бөгөөд тэр «Израилийн хөвгүүдийн Түүнд тогтоосон үнэ болох гучин мөнгөн зоосыг тэд авч, ¹⁰Эзэний надад айлдсан ёсоор Ваарчны Талбайг худалдан авав» гэж хэлсэн байжээ.

¹¹Есүс захирагчийн өмнө зогсов. Захирагч Түүнээс

—Та иудейчүүдийн Хаан мөн юм уу? гэж асуухад Есүс

—Та ч хэлж байна гэв. ¹²Ахлах тахилч нар болон ахлагчид Есүсийг буруутгахад Тэр юу ч хариулсангүй. ¹³Пилат Түүнд

—Тэд Таны эсрэг хичнээн олон зүйл гэрчилж байгааг Та сонсохгүй байна уу? гэхэд ¹⁴Тэр түүнд нэг ч үг хэлсэнгүйд захирагч ихэд гайхжээ. ¹⁵Захирагч баяраар ард олны хүсэлтээр нэг хоригдлыг сулладаг заншилтай байв. ¹⁶Тэр үед тэд Бараб гэгч зард гарсан хоригдлыг хорьсон байлаа. ¹⁷Тэгээд ард олныг цуглах үед Пилат тэдэнд

—Та нар хэнийг суллуулахыг надаас хүсэж байна? Барабыг уу, эсвэл Христ гэгдэх Есүсийг үү? гэлээ. ¹⁸Учир нь Түүнийг тэд атаархсандаа барьж өгснийг тэр мэдэж байлаа. ¹⁹Пилатыг шүүгчийн суудалд сууж байх үед эхнэр нь түүнд

—Тэр зөвт Хүнд юу ч бүү хий. Би урьд шөнө зүүдэндээ Түүнээс болж ихэд шаналав гэж хэлүүлжээ. ²⁰Харин ахлах тахилч нар болоод ахлагчид олон түмнийг Барабын төлөө гуйж, харин Есүсийг хөнөөлгөхийг ятгасан байлаа. ²¹Захирагч тэдэнд

—Энэ хоёрын хэнийг нь суллуулмаар байна? гэхэд тэд

—Барабыг гэцгээлээ. ²²Тэгтэл Пилат

—Тэгвэл Христ гэгдэх Есүсийг би яах болж байна? гэсэнд тэд бүгд л

—Түүнийг цовдол гэцгээв. ²³Пилат

—Яагаад, Тэр ямар муу юм үйлдсэн юм бэ? гэж асуусанд харин тэд бүгд

—Түүнийг цовдол гэж улам чанга хашхирч байлаа. ²⁴Пилат энэ нь яавч нэмэргүй, харин ч бүр үймээн самуун дэгдэж эхлэхийг хараад, ус авч, хурсан олны өмнө гараа угаан

—Би энэ Хүний цусанд буруугүй. Өөрсдөө мэдтүгэй гэжээ. ²⁵Тэгтэл бүх хүмүүс

—Түүний цус бидний болон бидний үр хүүхдүүдийн дээр байг гэцгээв. ²⁶Тэгээд тэр Барабыг тэдэнд суллан, Есүсийг ташуурдсаны дараа цовдлуулахаар болжээ.

²⁷Тэгэхэд захирагчийн цэргүүд Есүсийг ордонд авчирж Ромын бүтэн ангийг цуглуулж Түүнийг тойруулав. ²⁸Тэд Түүнийг нүцгэлээд час улаан нөмрөг нөмөргөж, ²⁹үүргэнээр титэм сүлжсэний дараа толгой дээр нь тавьж, баруун гарт нь хулс атгуулжээ. Тэд Түүний өмнө сөгдөж,

—Иудейчүүдийн Хааныг мэндчилье хэмээн дооглон, ³⁰Түүн уруу нулимж, хулсыг нь аваад толгой уруу нь цохилоо. ³¹Тэд Есүсийг дооглосны дараа Түүнээс нөмрөгийг нь тайлж хувцсыг нь өмсгөв. Тэгээд Түүнийг цовдлохоор авч явлаа.

³²Тэд гарч явахдаа Курений Симон гэгчтэй тааралдаж түүнийг албадаж Есүсийн загалмайг үүрүүлэв.

³³Тэгээд тэд Гавлын Газар гэсэн утгатай Голгота гэдэг газарт хүрч ирээд ³⁴цөстэй хольсон дарсыг Түүнд уулгахаар өгөв. Тэр хэдийгээр амссан ч уухгүй байв. ³⁵Тэд Түүнийг цовдолсны дараа, хоорондоо шодон хувцсыг нь хувааж аваад, ³⁶суун тэндээ Түүнийг харгалзаж байв. ³⁷Тэд Түүний толгойн дээр «Энэ бол Есүс, иудейчүүдийн Хаан» гэж бичсэн пайзыг хадлаа. ³⁸Тэр үед Түүнтэй хамт хоёр дээрэмчин цовдлуулж, нэг нь баруун талд, нөгөө нь зүүн талд байлаа. ³⁹Дэргэдүүр нь өнгөрөгсөд толгой сэгсрэн, Түүнийг доромжилж

— ⁴⁰Сүмийг нурааж, гурав хоногийн дотор барьдаг хүн Чи Өөрийгөө авраач. Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол, загалмайнаасаа буугаач гэцгээж байлаа. ⁴¹Түүнчлэн ахлагч тахилч нар ч хуулийн багш нар болоод ахлагчдын хамт Түүнийг элэглэн дооглож,

— ⁴²Тэр бусдыг аварсан боловч Өөрийгөө аварч чаддаггүй. Тэр бол Израилийн Хаан. Тэр одоо загалмайнаасаа бууг, тэгвэл бид Түүнд итгэнэ. ⁴³Тэр Бурханд найдаж байсан биз дээ. Хэрэв Бурхан Түүнийг таалдаг юм

бол одоо л Түүнийг авраг. Энэ хүн чинь "Би бол Бурханы Хүү" гэсэн биз дээ гэцгээв. ⁴⁴Хамт цовдлогдсон дээрэмчид ч Түүнийг мөн доромжилж байлаа.

⁴⁵Зургадугаар цагаас есдүгээр цаг хүртэл бүх газрыг харанхуй нөмрөн авлаа. ⁴⁶Есдүгээр цагийн орчим Есүс чанга дуугаар

—Ели, Ели, лама сабахтани? гэж хашхирлаа. Энэ нь «Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?» гэсэн үг аж. ⁴⁷Тэнд зогсож байсан хүмүүсийн зарим нь үүнийг сонсоод,

—Энэ хүн Елиаг дуудаж байна гэв. ⁴⁸Тэдний нэг нь тэр даруй гүйж, далайн хөвөн авч, цагаан цуу шингээгээд, хулсанд торгоон, Түүнд уулгахаар өглөө. ⁴⁹Харин бусад нь

—Елиа Түүнийг аврахаар ирэх эсэхийг харцгаая гэв. ⁵⁰Есүс дахин чангаар хашхираад Өөрийн сүнсээ гаргажээ. ⁵¹Үзэгтүн, сүмийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон цуу урагдаж, газар хөдлөн, хад чулуу бут хагаран, ⁵²булш нээгдэн, нойрссон олон ариун хүмүүсийн биес амилуулагдаж, ⁵³Есүсийн амилалтын дараа булшнуудаасаа гарч ариун хотод орж, олон хүнд харагджээ. ⁵⁴Есүсийг харгалзаж байсан зуутын дарга болон харуулууд газар хөдлөлт болон болж буй бүхнийг хараад ихэд айн,

—Үнэхээр энэ хүн Бурханы Хүү байжээ гэв. ⁵⁵Есүст үйлчилж, Түүнийг Галилаас дагаж ирсэн олон эмэгтэйчүүд тэнд холоос харж байлаа. ⁵⁶Тэдний дунд Магдалын Мариа болон Иаков, Иосеф хоёрын эх Мариа, мөн Зебедеен хөвгүүдийн эх ч байв.

⁵⁷Орой нь Ариматаас Иосеф гэгч нэгэн баян хүн хүрч ирлээ. Тэр мөн өөрөө Есүсийн шавь болсон ажээ. ⁵⁸Энэ хүн Пилатад бараалхаж, Есүсийн цогцсыг гуйхад Пилат өгөхийг тушаав. ⁵⁹Иосеф цогцсыг аваад, цэвэр маалинган даавуунд ороож, ⁶⁰хаданд ухаж хийсэн өөрийнхөө шинэ булшинд тавьж, бул чулуу өнхрүүлэн булшны амыг таглаад явжээ. ⁶¹Тэнд Магдалын Мариа болон нөгөө Мариа булшны эсрэг талд сууж байв.

⁶²Дараа өдөр нь бэлтгэлийн өдрийн дараахь өдөр байсан бөгөөд ахлах тахилч нар болоод фарисайчууд Пилатынд цуглаж,

— ⁶³Эрхэм ээ, тэр мэхлэгч амьд байхдаа "Би гурав хоногийн дараа амилна" гэж хэлж байсныг бид санаж байна. ⁶⁴Тиймээс шавь нар нь ирж Түүнийг хулгайлан аваад, ард олонд "Тэр үхэгсдээс амилав" гэж хэлүүлэхгүйн тул гурав дахь өдөр нь хүртэл булшийг хамгаалахыг

тушаагаач. Хэрэв тэгэхгүй бол сүүлчийн мэхлэлт нь эхнийхээсээ ч дор муу юм болно гэцгээлээ. ⁶⁵Пилат тэдэнд,

—Харуул аваад яв, хэрхэн хамгаалахаа та нар өөрсдөө мэдэж байгаа биз ээ гэв. ⁶⁶Тэд очоод хадан дээр лац тавьж, харуул гарган булшийг манацгаав.

[28]

¹Амралтын өдрийн дараа долоо хоногийн эхний өдөр үүрээр Магдалын Мариа болон нөгөө Мариа нар булшийг үзэхээр ирэв. ²Харагтун. Маш хүчтэй газар хөдлөлт болжээ. Учир нь Эзэний тэнгэр элч тэнгэрээс буун ирж чулууг зайлуулаад дээр нь суужээ. ³Түүний дүр аянга лугаа адил хувцас нь цас шиг цагаан байв. ⁴Харуулууд түүнээс айн чичирч, үхсэн мэт болжээ. ⁵Тэгтэл тэнгэр элч эмэгтэйчүүдэд

—Бүү ай. Загалмайд цовдлогдсон Есүсийг хайж байгааг чинь би мэдэж байна. ⁶Тэр энд байхгүй. Учир нь хэлж байснаараа Тэр амилсан. Ирэгтүн. Түүний хэвтэж байсан газрыг үзэгтүн. ⁷Хурдан очиж, шавь нарт нь "Тэр үхэгсдээс амилжээ. Тэр та нараас түрүүнд Галилд хүрэх тул та нар тэнд Түүнийг харах болно" гэж хэл. Харагтун. Би та нарт хэллээ гэв. ⁸Тэд айдас болон баяр хөөртэйгөөр булшийг хурдан орхиж, шавь нарт нь мэдэгдэхээр гүйлдлээ. ⁹Үзэгтүн. Есүс тэдэнтэй уулзаж,

—Амар байна уу? гэхэд тэд дөхөн очоод Түүний хөлөөс зуурч, Түүнд мөргөлөө. ¹⁰Тэгээд Есүс тэдэнд

—Бүү ай. Явж, ах дүүст маань Галил уруу яв гэж мэдэгд. Тэнд тэд Намайг харах болно гэж айлдлаа.

¹¹Тэднийг замдаа явж байх зуур харуулуудын зарим нь хотод ирж, ахлах тахилч нарт болсон бүхнийг мэдэгдэв. ¹²Тэд ахлагчидтай уулзаад зөвлөлдөн, цэргүүдэд их хэмжээний мөнгө өгөөд,

— ¹³Та нар "Шавь нар нь шөнө ирээд, биднийг унтаж байх зуур Түүнийг хулгайлчихлаа" гэж хэл. ¹⁴Хэрэв энэ нь захирагчийн сонорт хүрэх юм бол бид ятгаж, та нарыг гайгаас мултална гэжээ. ¹⁵Тэд мөнгийг аваад, заасан ёсоор нь гүйцэтгэв. Энэ түүх иудейчүүдийн дунд энэ өдрийг хүртэл өргөн тархсан байна. ¹⁶Харин арван нэгэн шавь нь Галилын зүг, Есүсийн товлосон уул уруу явав. ¹⁷Тэд Есүсийг хармагцаа Түүнд мөргөлөө. Харин зарим нь эргэлзэж байлаа. ¹⁸Есүс ойртон ирээд, тэдэнд

—Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. ¹⁹Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, ²⁰Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.